

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар А/116

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журмыг шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Г.Энхтүвшин)-т даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Бекболат)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2025 оны “Журам батлах тухай” 217 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.НАЙДАЛАА

*Эрчим хүчний сайдын 2026 оны 5 дугаар сарын 22-ны
өдрийн А/116 дугаар тушаалын хавсралт*

**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮР БАРИХ ТӨСӨЛ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ**

I ХЭСЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ журмаар сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл (цаашид “төсөл” гэх) шалгаруулах үйл ажиллагааг төсөл сонгон шалгаруулах болон аукцион зохион байгуулах төрлөөр явуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл хэрэгжүүлэгч нь Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3.Энэ журамд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.3.1.“Төсөл” гэж нэгдсэн сүлжээнд холбогдон үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг худалдах зорилгоор нар, салхины үүсгүүр болон батарей хуримтлуур хосолсон системд хөрөнгө оруулах, барих, эрчим хүчийг үйлдвэрлэн, худалдахтай холбогдсон үйл ажиллагааг;

1.3.2.“Төсөл сонгон шалгаруулалт” гэж төслийг барьж байгуулах, цахилгаан эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулах эрхийг техникийн болон санхүүгийн үнэлгээний үндсэн дээр үнийн саналаар өрсөлдүүлэх зарчмаар сонгон шалгаруулахыг;

1.3.3.“Аукцион” гэж төслийг барьж байгуулах, цахилгаан эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулах эрхийг өрсөлдөөнт үнийн саналын үндсэн дээр дуудлага худалдааны зарчмаар сонгон шалгаруулахыг;

1.3.4.“Зохион байгуулагч” гэж төслийн захиалагч буюу эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Диспетчерийн үндэсний төв, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит хуулийн этгээд болон хороог;

1.3.5.“Хороо” гэж төсөл сонгон шалгаруулалт болон аукционыг явуулах чиг үүрэг бүхий дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 9-өөс доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгуулах бүтцийг ойлгох бөгөөд хорооны гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх ба хараат бус гишүүн нь эрчим хүчний салбарт 5 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай, худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан, төрийн үйлчилгээнээс бусад төрийн албанд ажилдаггүй байна.

1.3.6.“Хүсэлт” гэж аукционд оролцох сонирхлоо илэрхийлэх хүсэл зоригийг;

1.3.7.“Битүүмжилсэн үнийн санал” гэж оролцогчийн төсөл хөгжүүлэхтэй холбоотой зардлыг тусгасан нэгж цахилгаан эрчим хүчний үнэ буюу ам.цент/кВт.цаг-аар илэрхийлэгдэх үнийн саналыг;

1.3.8.“Аукционы ялагч” гэж энэхүү журамд заасан туршлага, санхүүгийн болон техникийн шаардлагыг хангаж, аукционоор хамгийн бага үнэ санал болгосон оролцогчийг;

1.3.9.“Дээд үнэ” гэж Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11.1.1, 11.1.3-т заасныг;

1.3.10.“Дэнчин” гэж аукционд оролцогч төсөл хэрэгжүүлэх нотолгоо болгон хорооны заасан дансанд тодорхой хугацаагаар байршуулах мөнгөн хөрөнгийг;

1.3.11.“Суурилагдсан хүчин чадал” гэж төслийн нэрлэсэн буюу суурилагдах нийт хүчин чадлыг МВт болон МВт.цаг-аар илэрхийлсэн хэмжээг;

1.4.Төсөл сонгон шалгаруулалт болон аукционаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүр батална.

1.5.Төсөл сонгон шалгаруулалтын хорооны хурал нь гишүүдийн 75-аас доошгүй хувь оролцсоноор хүчинтэйд тооцогдож, хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

II ХЭСЭГ.ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

Хоёр.Төсөл сонгон шалгаруулалтын үе шат

2.1.Төсөл сонгон шалгаруулалт нь төслийг нийтэд зарлах, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулах болон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах үе шатуудаас бүрдэнэ.

2.2.Оролцогч нь төсөл сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх, энэ журамд заасан шаардлага хангасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн түншлэл байна.

2.3.Төслийн захиалагч нь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй оролцоно:

2.3.1.төсөл сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийг батлах;

2.3.2.төсөл хэрэгжүүлэх гэрээний загварыг боловсруулах, батлах;

2.3.3.төсөл сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчтой холбогдох гэрээ байгуулах;

2.3.4.шаардлагатай тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтын хорооны санал болгосноор үнэлгээний хугацааг нэг удаа 45 хүртэлх хоногоор сунгах.

2.4.Диспетчерийн үндэсний төв нь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй оролцоно:

2.4.1.эрчим хүчний системийн судалгааг хийж, тухайн онуудад хэрэгжүүлэх хүчин чадал, байршлыг тодорхойлж, төслийн хэрэгцээ шаардлагын судалгааг төслийн захиалагчид жил бүр хүргүүлэх;

2.4.2.хэрэгцээ шаардлагад заасан төслийн нэгдсэн сүлжээнд үзүүлэх нөлөөлөл, горим тогтворжилтын тооцоо, дүгнэлт бусад шаардлагатай мэдээллээр төслийн захиалагчийг хангах;

2.4.3.шалгарсан төсөл хэрэгжүүлэгчтэй эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах.

2.5.Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит хуулийн этгээд нь төслийн шалгаруулалтад ашиглах төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон холбогдох бусад баримт бичгийг боловсруулна.

2.6.Хороо нь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй оролцоно:

2.6.1.төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, төслийн захиалагчаар батлуулах;

2.6.2.төслийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах;

2.6.3.энэ журмын дагуу төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

2.6.4.төслийг шалгаруулсан тухай зөвлөмжийг гаргаж, төслийн захиалагчид хүргүүлэх;

2.6.5.төсөл сонгон шалгаруулалтын хорооны гишүүн нь үүрэгт ажлаа хараат бусаар хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;

2.6.6.энэ журмын 3.2.3-т заасан төсөл хэрэгжүүлэх баталгааны хэмжээг энэ журамд заасан хязгаарт батгаан тогтоох;

2.6.7.хууль тогтоомжид заасан бусад.

Гурав.Төсөл сонгон шалгаруулалтыг нийтэд зарлах

3.1.Төслийн захиалагч нь төсөл сонгон шалгаруулалтын урилгыг урьдчилсан үнэлгээ эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө өөрийн цахим хуудас болон олон улсад өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

3.2.Энэ журмын 3.1-д заасан хугацаанд төслийн захиалагчийн цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулах замаар оролцогч нарыг шалгаруулалтад оролцуулах бэлтгэл ажлыг хангана:

3.2.1.төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт;

3.2.2.ирүүлэх маягтын загвар;

3.2.3.төсөл хэрэгжүүлэх баталгаа, түүний хэмжээ нь санал болгож байгаа хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 1-5 хүртэл хувьтай тэнцүү байна;

3.2.4.энэ журмын 2.5-т заасан баримт бичгийг худалдан авах холбоос.

3.3.Энэ журмын 3.2.4-т заасны дагуу худалдан авах төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дараах мэдээллийг зайлшгүй тусгасан байна:

3.3.1.сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа;

3.3.2.тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг;

3.3.3.горим, тогтворжилтын тооцоо;

3.3.4.хөрөнгө оруулалт, эдийн засгийн шинжилгээ (WACC, IRR, NPV).

3.4.Энэ журмын 3.3-т заасан баримт бичгийг боловсруулсан зардлыг доор дурдсан аргачлалын дагуу тооцож, баримт бичгийг худалдан авах үнийг тодорхойлно:

$$\text{Зардал} = I + P * q + L + T + G + C$$

I - суурь төлбөр - тавин мянган нэгж;

P - суурилагдсан хүчин чадал (Ватт);

q - итгэлцүүр (нарны цахилгаан станц-3, салхин цахилгаан станц-5);

L - газрын төлбөр;

T - Эрчим хүчний зохицуулах хорооноос олгох тусгай зөвшөөрлийн хураамж;

G - Горим, тогтворжилтын тооцооны төлбөр;

C - Бусад зардал (зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан зардал).

3.5.Төсөл сонгон шалгаруулалтын урилгыг нийтэд зарласнаас хойш төслийн үнэлгээний аргачлал, 3.2-т заасан бичиг баримт болон холбогдох бусад баримт бичигт өөрчлөлт оруулахгүй.

3.6.Төсөл сонгон шалгаруулалтын хороо нь төсөл сонгон шалгаруулалтын үйлчилгээний хөлс, шалгаруулалтад оролцох санал хүлээн авах хаяг, хугацаа зэрэг мэдээллийг зар дээр тодорхой бичнэ.

Дөрөв.Төсөл сонгон шалгаруулалтад оролцох санал хүлээн авах

4.1.Төслийн захиалагч нь төсөл сонгон шалгаруулалтын санал хүлээн авах, төсөл сонгон шалгаруулах цахим платформ бүхий мэдээллийн дэд бүтцийг бий болгож, үйл ажиллагаа явуулах найдвартай орчинг бүрдүүлсэн байна.

4.2.Оролцогч нь энэ журмын 3.1-д заасан хугацаанд урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтээ цахимаар хүргүүлэх ба нэг оролцогч нэг төсөлд санал ирүүлнэ.

4.3.Оролцогч нь урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтийн хамт хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, түншлэл бол түншлэлийн оролцогч хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар болон түншлэлийн гэрээ, талуудын сүүлийн 5 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн баталгаажуулсан хуулбар, туршлагын талаарх мэдээллийг ирүүлнэ.

Тав.Төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

5.1.Хороо нь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа доорх дарааллаар үнэлгээ хийнэ:

5.1.1.урьдчилсан үнэлгээ;

5.1.2.техникийн үнэлгээ;

5.1.3.санхүүгийн үнэлгээ.

5.2.Урьдчилсан үнэлгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.2.1.хороо нь энэ журмын 4.3-т заасан хүсэлтийг хүлээн авч, сүүлийн 5 жилийн ажлын туршлага, санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтийг хангаж буй шаардлага хангасан оролцогчийн жагсаалтыг гаргана;

5.2.2.хороо төслийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, урьдчилсан үнэлгээгээр өндөр оноо авсан эхний 5 хүртэл оролцогчийг эрэмбэлэн төслийн захиалагчид хүргүүлнэ;

5.2.3.хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн төслийн захиалагч холбогдох шийдвэрийг гаргаж, тэнцсэн оролцогчийг дараагийн шатны шалгаруулалтад урина;

5.2.4.энэ журмын 5.2.3-т заасны дагуу шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгарсан оролцогч болон бусад оролцогчид урьдчилсан шалгаруулалтын шийдвэрийг цахимаар мэдэгдэж, тэнцсэн оролцогчийн талаар төслийн захиалагчийн цахим хуудас болон олон улсад өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.3.Техникийн үнэлгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.3.1.хороо нь урьдчилсан үнэлгээний үе шатанд тэнцсэн оролцогчид дараах мэдээлэл бүхий санал ирүүлэх урилгыг цахимаар хүргүүлнэ:

5.3.1.1.төслийн нэр, суурилагдсан хүчин чадал, төсөл хэрэгжүүлэх байршил, техник, технологийн шийдэл, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний хэмжээ;

5.3.1.2.санхүүгийн болон хүний нөөцийн чадавхын талаарх мэдээлэл, холбогдох зөвшөөрлүүд (тогтоосон маягтын дагуу);

5.3.1.3.үнийн санал (тогтоосон маягтын дагуу);

5.3.1.4.техникийн болон санхүүгийн санал боловсруулахад шаардлагатай мэдээлэл;

5.3.1.5.техникийн болон санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлт;

5.3.1.6.төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх нарийвчилсан төлөвлөгөө;

5.3.1.7.төсөл сонгон шалгаруулалт хүчингүй болох нөхцөл;

5.3.1.8.төсөл хэрэгжүүлэх гэрээний загвар;

5.3.1.9.эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загвар;

5.3.1.10.санал нээхээс өмнө тодруулга өгөх тухай;

5.3.1.11.төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа, хүлээн авах газар.

5.4.Оролцогч нь төслийн техникийн болон санхүүгийн саналыг тус тусад нь боловсруулж, цахимаар, тогтоосон хугацаанд ирүүлнэ.

5.5.Хороо нь төслийн техникийн болон санхүүгийн саналыг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор үнэлнэ.

5.6.Техникийн саналд 70 болон түүнээс дээш хувь авсан оролцогчийн санхүүгийн саналыг нээнэ.

5.7.Санхүүгийн үнэлгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.7.1.төсөл сонгон шалгаруулалтын хороо оролцогчийн санхүүгийн саналыг эрэмбэлж, эх үүсвэрээс 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний хамгийн бага тариф (НӨАТ-гүй)-ын санал ирүүлсэн төслийг шалгаруулж, зөвлөмж, тайланг төслийн захиалагчид хүргүүлнэ;

5.7.2.энэ журмын 5.7.1-д заасан тайланд төслийн урьдчилсан шалгаруулалтын үнэлгээний талаар болон техник, санхүүгийн саналыг үнэлсэн тайланг тус тус дэлгэрэнгүй бэлтгэж, тусгана;

5.7.3.энэ журмын 5.7.1-д заасан зөвлөмж ирүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор төслийн захиалагч нь холбогдох шийдвэрийг зөвлөмжид үндэслэн гаргаж, шийдвэрийг техникийн болон санхүүгийн санал ирүүлсэн оролцогчид тус тус мэдэгдэнэ.

Зургаа.Шалгарсан оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулах

6.1.Төслийн захиалагч төсөл нь шалгарсан оролцогчтой хэлцэл хийх ажлын хэсгийг байгуулж, энэ журмын 5.7.1-д заасан хамгийн бага тариф санал болгосон оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулна.

6.2.Шалгарсан оролцогч нь хэлцлийн явцад ирүүлсэн техникийн болон санхүүгийн саналаа өөрчлөхгүй.

6.3.Энэ журмын 6.1-д заасан оролцогчтой тохиролцоонд хүрээгүй бол уг хэлцлийг цуцалж, дараагийн бага тариф санал болгосон оролцогчийг хэлцэлд урина.

6.4.Энэ журмын 6.2-т заасныг зөрчсөн, 6.1, 6.3-т заасны дагуу тохиролцоонд хүрээгүй оролцогчийн төсөл хэрэгжүүлэх баталгааг буцаан олгохгүй.

6.5.Төсөл сонгон шалгаруулалтад шалгараагүй оролцогчийн төсөл

хэрэгжүүлэх баталгааг төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор буцаан олгоно.

6.6.Төслийн захиалагч нь гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор дараах мэдээллийг цахим хуудсандаа байршуулна:

6.6.1.төсөл сонгон шалгаруулалтын баримт бичиг;

6.6.2.урьдчилсан үнэлгээнд төсөл ирүүлсэн оролцогчийн тоо;

6.6.3.урьдчилсан үнэлгээний шатанд шалгарсан оролцогчийн нэр;

6.6.4.төсөл сонгон шалгаруулалтын шатанд техникийн болон санхүүгийн санал ирүүлсэн оролцогчийн нэр;

6.6.5.санхүүгийн саналыг үнэлсэн оролцогчийн нэр;

6.6.6.төсөл нь шалгарсан оролцогчийн нэр, ирүүлсэн үнийн санал;

6.6.7.хорооны гишүүдийн тухай.

6.7.Төсөл сонгон шалгаруулалт дууссаны дараа ирүүлсэн материалыг төслийн захиалагчийн архивт шилжүүлнэ.

Долоо.Гомдол

7.1.Оролцогч нь урьдчилсан үнэлгээний, эсхүл эцэслэн шалгаруулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ журмын 5.2.4, 5.7.3-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор гомдлоо төслийн захиалагчид гаргана.

7.2.Төслийн захиалагч нь гомдлыг хүлээн авч ажлын 5 хоногт багтаан шалгаруулалтын материалтай танилцаж, дахин үнэлгээ хийх эсэх талаар шийдвэр гарган, энэ талаар цахим хуудсаар дамжуулан оролцогч нарт мэдэгдэнэ.

7.3.Төслийн захиалагч нь дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн бол холбогдох материалыг дахин үнэлж, шийдвэрийг энэ журмын 7.2-т заасан мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 3 хоногт багтаан гаргаж, оролцогч нарт мэдэгдэнэ.

7.4.Энэ журмын 7.2-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол гаргасан этгээд нь холбогдох хуулийн дагуу шүүхэд хандана.

III ХЭСЭГ.АУКЦИОН ЗОХИОН БАЙГУУЛАХ

Найм.Аукцион зохион байгуулах үе шат

8.1.Аукционыг дараах гурван үе шаттай зохион байгуулна.

8.1.1.аукционыг нийтэд зарлах, хүсэлт хүлээн авах;

8.1.2.аукционы урилгыг нийтлэх, оролцогчдыг бүртгэх;

8.1.3.аукцион явуулах.

8.2. Хороо нь аукционы техникийн ерөнхий шаардлага, санхүүгийн болон туршлагын шаардлагыг тодорхойлж, дараах чиг үүргийг

хэрэгжүүлнэ:

8.2.1.төсөл тус бүрийн байршлыг урьдчилан тодорхойлох;

8.2.2.үүсгүүрийн техникийн үндсэн үзүүлэлт, суурилагдсан чадал, батарей хуримтлуурын чадал болон багтаамж, сүлжээнд холбогдох цэг, ашиглалтад оруулах хугацаа, жилд худалдан авах цахилгаан эрчим хүчний доод хэмжээг урьдчилан тогтоох;

8.2.3.оролцогчоос тодруулга ирүүлсэн тохиолдолд хариуг аукцион болох өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө хүргүүлэх.

8.2.4.оролцогчдод нэгдсэн мэдээлэл өгөх арга хэмжээг аукцион болох өдрөөс өмнө зохион байгуулах.

8.2.5.аукционы ялагчийг нийтэд зарлах, гэрээ байгуулах, холбогдох зөвшөөрөл авахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх.

8.3.Аукционыг ашиг сонирхлын зөрчилгүй, ил тод, шударга, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмаар зохион байгуулна.

Ес.Аукционыг нийтэд зарлах, хүсэлт хүлээн авах

9.1.Хороо нь аукцион эхлэхээс 40-өөс доошгүй хоногийн өмнө зохион байгуулагчийн цахим хуудас, эсхүл олон улсын өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр аукционыг нийтэд зарлаж, хүсэлт хүлээн авах талаар мэдэгдэнэ.

9.2.Зарлал нийтлэгдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор хүсэлтийг хүлээж авах ба сонирхогч этгээдийн хүсэлтийн хамт дараах баримт бичгийг ирүүлнэ:

9.2.1.компанийн үйл ажиллагааны танилцуулга, барих-өмчлөх-ашиглах түүнтэй ижил төстэй төслүүдэд оролцсон болон хэрэгжүүлсэн туршлага, цахилгаан станцын зураг төсөл, барилгын ажил гүйцэтгэж байсан туршлага, төслийг санхүүжүүлэх чадавх зэргийг нотолсон баримт бичиг;

9.2.2.хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

9.2.3.сүүлийн 2 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан;

9.2.4.компанийн үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан болон холбогдох баримт бичиг.

Арав.Аукционы урилгыг нийтлэх, оролцогчдыг бүртгэх

10.1.Хороо ирсэн хүсэлтэд үндэслэн оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагыг тодорхойлно.

10.2.Хороо нь аукцион эхлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө аукционы урилгыг нийтэлж, дараах мэдээллээр хангана. Үүнд:

10.2.1.төслийн байршлын мэдээлэл, сүлжээний холболтын цэг;

10.2.2.нар, салхины цахилгаан станцын чадал, МВт (MWac);

10.2.3.батарей хуримтлуурын системийн ашиглах багтаамж (ашиглаж болох эрчим хүч, МВт.ц);

10.2.4.батарей хуримтлуурын системийн хувиргуурын чадал, (PCS);

10.2.5.жилд худалдан авах цахилгаан эрчим хүчний хэмжээ, сая.кВт.ц;

10.2.6.цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загвар, хэрэгжих хугацаа;

10.2.7.үнийн дээд хязгаар, ам.цент/кВт.ц;

10.2.8.аукционы дэнчинг байршуулах гэрээний загвар;

10.2.9.ашиглалтад оруулах эцсийн хугацаа;

10.2.10.техникийн нөхцөл, техникийн ерөнхий шаардлага;

10.2.11.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг нэгдсэн сүлжээнд ажиллах үеийн горимын тооцоо.

10.3.Энэ журмын 10.2-т заасан баримт бичгийг худалдан авах холбоосыг аукционы урилгад тусгана.

10.4.Дараах этгээд аукционд оролцох эрхтэй:

10.4.1.Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд дангаар болон түншлэлээр;

10.4.2.гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдтэй түншлэлээр;

10.4.3.хүсэлт ирүүлээгүй этгээд.

10.5.Оролцогч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

10.5.1.төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлагатай байх;

10.5.2.дампуурал, татан буулгалт, төлбөрийн чадваргүй болоогүй байх;

10.5.3.түншлэлээр оролцогч гадаадын хуулийн этгээд нь өөрийн бүртгэлтэй улсын хууль тогтоомжийн дагуу татвар, хөрөнгө оруулалт оруулах санхүүгийн чадавхаа нотолсон баримт бичигтэй байх;

10.5.4.авлига, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, хориг арга хэмжээ хэрэгжүүлдэггүй байх;

10.5.5.оролцогч, түншлэлийн гишүүн, тэдгээрийн эцсийн өмчлөгч, толгой компани нь олон улсын санхүүгийн болон хөгжлийн байгууллагын эрх хасах, хориг арга хэмжээний жагсаалтад бүртгэгдээгүй байх.

10.6.Нэг оролцогч нэг дор зарласан хэдэн ч төсөлд хүсэлт ирүүлж болох бөгөөд зөвхөн нэг төсөлд оролцоно. Нэг оролцогчийн аукционд оролцох хугацаа хоорондын зай 6 сараас доошгүй байна.

10.7.Аукционд оролцогчид бүртгүүлэхээр аукцион болох өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

10.7.1.төлөөлөх бүрэн эрх олгох итгэмжлэл;

10.7.2.горимын тооцоо, техникийн нөхцөлийн шаардлагыг

хангасан техникийн санал;

10.7.3.барилга угсралтын ажлын хуваарь;

10.7.4.үл маргах журмаар дэнчин алдах мэдэгдэл (журмын 14.7 дахь заалт);

10.7.5.хэрэв түншлэл бол түншлэлийн гэрээ;

10.7.6.сонирхлоо илэрхийлсэн хүсэлт ирүүлээгүй болон түншлэл өөрчлөгдсөн бол оролцогч 9.2-т заасан бичиг баримт;

10.7.7.санхүүгийн болон туршлагын чадавхын мэдээлэл (тогтоосон маягтын дагуу);

10.7.8.техникийн ерөнхий шаардлагын мэдээлэл (тогтоосон маягтын дагуу);

10.7.9.оролцогч нь энэ аргачлалын 10.5-д заасан ерөнхий шаардлагыг хангасныг илэрхийлсэн мэдэгдлийг, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд 10.5.1-д заасан шаардлагыг хангаж байгаа талаарх эрх бүхий байгууллагын лавлагааг ирүүлнэ.

10.8.Оролцогч нь дээрх баримт бичгийг Монгол хэл эсхүл Англи хэл дээр хорооны заасан цахим шуудангийн хаягт ирүүлнэ.

10.9.Хороо нь оролцогчийн 10.6-д заасан бүртгэлийн бичиг баримт хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор бүрдлийг хянаж, шаардлага хангасан тохиолдолд оролцогчоор бүртгэнэ.

10.10.Бүртгэл баталгаажсан оролцогчид дэнчинг байршуулах талаар холбогдох мэдээллийг хүргэнэ.

10.11.Оролцогч нь аукционы дэнчиг аукцион болох өдрөөс 1 өдрийн өмнө Диспетчерийн үндэсний төвийн дансанд байршуулна.

10.12.Оролцогч нь техникийн саналыг хорооноос тогтоосон маягтын дагуу бэлтгэж ирүүлнэ.

10.13.Оролцогч нь аукционы үнийг санал болгохдоо хорооноос тогтоосон маягтын дагуу зардлуудыг бүрэн багтааж тооцох үүрэг хүлээх бөгөөд дутуу тооцсон зардлыг өөрөө хариуцна.

10.14.Дуудлага худалдааны явц болон үр дүнгийн талаарх тэмдэглэлд оролцогч гарын үсэг зурна.

10.15. Оролцогч нь хорооноос тодорхойлон заасан төлбөр хүлээн авагчтай дэнчин байршуулах гэрээ байгуулан, гэрээнд буюу энэ журмын 10.11-т заасан дансанд дэнчинг байршуулна.

10.16.Дэнчин байршуулсныг баталгаажуулснаар аукционд оролцох эрх үүснэ.

Арван нэг.Аукцион явуулах

11.1.Аукционыг танхимаар эсхүл цахимаар зохион байгуулна.

11.2.Оролцогчийг төлөөлж аукционд түүний хууль ёсны төлөөлөгч оролцоно.

11.3.Оролцогч аукционд хуулийн шаардлага хангасан

итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөгчөө оролцуулж болно. Оролцогч нь түншлэлийн хэлбэрээр оролцож байгаа тохиолдолд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж оролцоно.

11.4.Оролцогч нь битүүмжилсэн үнийн саналыг аукцион эхлэхээс 1 цагийн өмнө тусгайлан бэлтгэсэн хайрцагт байршуулна.

11.5.Хороо нь тогтоосон огноо, цагт оролцогчдоос битүүмжлэн ирүүлсэн үнийн саналын хамгийн доод үнийг харуулж аукционыг нээнэ.

11.6.Аукцион нь үнийг бууруулан дуудах хэлбэрээр явагдана.

11.7.Аукционы үед оролцогчдын нэрийг нууцлан, тусгай дугаар олгоно. Оролцогчид аукционд оноосон тусгай дугаараа ашиглан үнэ хаялцана.

11.8.оролцогчдод аукционы явцад оролцогчийн өгсөн үнийн санал болон тус саналыг өгсөн хугацаа, тухайн үеийн хамгийн бага үнэ, аукционы нийт болон үлдсэн хугацаа талаарх мэдээлэл ил тод байна.

11.9.Үнэ хаялцах үйл явцыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

11.9.1.үнийн санал буурах хамгийн бага хэмжээ 0.05 ам.цент/кВт.ц байна.

11.9.2.оролцогч нь аукцион үргэлжлэх хугацаанд нэгээс дээш санал гаргах эрхтэй. Оролцогчийн гаргах дараагийн санал нь түүний өмнөх саналаас бага байх бөгөөд тухайн үеийн хамгийн бага саналаас доогуур байна.

11.9.3.аукцион үргэлжлэх хугацаа 90 минут хүртэл байна.

11.9.4.хороо нь сүүлийн үнийн саналыг зарласнаас хойш 5 минутын хугацаанд түүнээс бага үнийн санал ирэхийг хүлээнэ. Уг хугацаанд шинэ, түүнээс бага үнийн санал ирээгүй тохиолдолд сүүлийн үнийг гурван удаа давтан зарлаж, гурваас нэг хүртэл тоолсны дараа хамгийн бага үнийн санал гаргасан оролцогчийг ялагчаар тодруулж, дуудлага худалдааг дуусгавар болсонд тооцно.

11.9.5.битүүмжилсэн үнийн саналын хамгийн доод үнэ тэнцсэн бөгөөд 5 минутын хугацаанд үнийн шинэ санал ороогүй тохиолдолд аукционыг хаагдсанд тооцож, ялагчийг тодруулна. Ижил үнийн санал ирүүлсэн оролцогчдоос 10.6-д заасан бүртгэлийн баримт бичгээ цаг хугацааны хувьд түрүүлж ирүүлсэн оролцогчийг аукционы ялагчаар шалгаруулна.

11.9.6.оролцогч илт алдаатай үнийн санал ирүүлсэн тохиолдолд хороо уг алдааг механик болон бичилтийн эсэхийг оролцогчоос баталгаажуулна. Оролцогч алдааг баталгаажуулсны дараа тухайн үеийн хамгийн бага үнийн саналыг цахим системд/дэлгэцэнд дахин байршуулна.

Арван хоёр.Аукционыг түр зогсоох болон цуцлах

12.1.Техникийн болон сүлжээний саатал үүссэн тохиолдолд

аукционыг 60 минут хүртэл хугацаагаар түр зогсооно.

12.2.Энэ журмын 12.1-т заасан нөхцөл байдал арилсан тохиолдолд аукционыг хамгийн сүүлд дуудсан бага үнийн саналаас үргэлжлүүлнэ.

12.3.Дараах тохиолдолд аукционыг цуцална:

12.3.1.аукционд 2-оос цөөн оролцогч санал ирүүлсэн тохиолдолд;

12.3.2.ирүүлсэн бүх санал дээд үнээс өндөр тохиолдолд;

12.3.3.энэ журмын 12.1-т зааснаас дээш хугацаанд саатал үргэлжлэх тохиолдолд.

12.4.Хороо энэ журмын 12.3-т заасан тохиолдолд энэ тухай шийдвэр гаргана. Шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор аукционыг дахин зохион байгуулна.

Арван гурав.Аукционы үр дүн

13.1.Аукционы хугацаа дуусахад оролцогчдын ирүүлсэн үнийн саналыг өсөх дарааллаар эрэмбэлэх бөгөөд хамгийн доод үнийн саналаар аукционы ялагчийг тогтооно.

13.2.Хороо нь аукцион хаагдсанаас хойш 60 минутын дотор дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулна:

13.2.1.төслийн ерөнхий мэдээлэл;

13.2.2.аукционы ялагчийн нэр;

13.2.3.аукционы ялагчийн дуудсан хамгийн доод үнийн санал (ам.цент/кВт.ц).

13.3.Аукцион зохион байгуулагдсан өдрөөс хойш ажлын 1 өдрийн дотор оролцогчдод шалгарсан эсэх талаар мэдэгдэл хүргүүлнэ.

13.4.Эрх бүхий этгээд аукционы ялагчид цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг олгох бөгөөд аукцион зохион байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор энэ тухай мэдэгдэл хүргүүлнэ.

13.5.Аукционы ялагчаас шаардлагатай тохиолдолд эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хувийг гэрээ байгуулахаас өмнө шаардан авч болно.

Арван дөрөв.Дэнчин

14.1.Аукционд оролцогч нь хорооны заасан дансанд төлбөр хүлээн авагчтай дэнчин байршуулах гэрээ байгуулна.

14.2.Оролцогч аукцион болох өдрөөс 1 хоногийн өмнө дансанд дэнчинг байршуулсан байна.

14.3.Дэнчингийн хэмжээ нь нар, салхины цахилгаан станц болон батарей хуримтлуур 1 МВт тутамд 5000.0 ам.доллар (таван мянган америк доллар) байна.

14.4.Дэнчинг дараах тохиолдолд буцаан олгоно:

14.4.1.оролцогч аукционд шалгараагүй тохиолдолд аукцион

зохион байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор.

14.4.2.аукцион цуцлагдсан тохиолдолд цуцлах шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор.

14.5.Аукционы ялагчтай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаанд тооцон шилжүүлнэ.

14.6.Ялагч дараах тохиолдолд дэнчинг алдана:

14.6.1.цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахаас зайлсхийсэн;

14.6.2.авлига, ашиг сонирхлын зөрчил, тохиролцоо, үгсэн хуйвалдаан болон бусад хууль зөрчсөн үйлдэл гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.

Арван тав.Гомдол

15.1.Аукционд оролцогч нь аукционы ялагч зарлагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хороонд бичгээр гомдол гаргах эрхтэй. Энэ тохиолдолд дэнчинг буцаан олгох хугацааг гомдол шийдвэрлэгдэх хүртэл хугацаагаар хойшлуулна.

15.2.Хороо нь гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

15.3.Гомдол хянан шийдвэрлэгдэх хүртэл хорооны шийдвэрээр цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг түр түдгэлзүүлнэ.

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 7598 дугаарт бүртгээл*

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/188

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газар /Я.Эрдэнэсайхан/-т үүрэг болгосугай.

3.Тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтэс /Ч.Раднаабазар/-т даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.ИДЭРБАТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/188 дугаар тушаалын хавсралт

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.Сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (цаашид “ЖДҮҮЭ” гэх)-ээр дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгуулсан “Хоршоог хөгжүүлэх сан” (цаашид “Сан” гэх)-г бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, төсөл сонгон шалгаруулах, сангаас зээл олгох, эргэн төлүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Сан нь Төрийн санд тусгай данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.3.Сан нь Төрийн сангаас гадуур данстай байхыг хориглох бөгөөд журмын 1.2-т заасан дансанд хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхээс бусад төрлийн санхүүжилт байршуулахыг хориглоно.

1.4.Сангийн орлого, зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгагдана.

1.5.Сангийн хөрөнгө нь хоршоо, ЖДҮҮЭ-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, сургалт зохион байгуулах, борлуулалтыг дэмжих, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана.

1.6.Санд зээлийн хүсэлт ирүүлсэн хоршоо, ЖДҮҮЭ-ийн төсөл (цаашид “төсөл” гэх)-ийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий төсөл сонгон шалгаруулах хороо (цаашид “хороо” гэх), хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл тус тус ажиллана.

1.7.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан үйл ажиллагааг эрхэлдэг хоршоо, ЖДҮҮЭ-д сангаас зээл олгохгүй.

ХОЁР.САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

2.1.Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1.Улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

2.1.2.Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй

тусламж, хандив;

2.1.3.Сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;

2.1.4.Сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;

2.1.5.Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги;

2.1.6.Бусад.

2.2.Санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, зээлийн эргэн төлөлт, ашиглалт, хэрэгцээ шаардлага, орон нутгийн идэвх санаачилга зэргийг харгалзан жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тогтооно.

2.3.Сангийн хөрөнгийг зориулалтын бус, үр ашиггүй зарцуулсан нь энэ журмын 7.1-т заасан зохистой харьцааны шалгуур хангаагүй болон бусад эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон бол төсөв, санхүүгийн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан шийдвэрээр сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэн дахин хуваарилж болно.

2.4.Суманд хуваарилагдсан хөрөнгийн эх үүсвэрийг энэ журмын 2.2, 2.3-т заасан эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр татан төвлөрүүлэх, дахин хуваарилахыг хориглоно.

2.5.Сангаас хоршоо, ЖДҮҮЭ-д олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна:

2.5.1.Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ жилийн 5 хувь;

2.5.2.Зээлийн хугацаа 60 хүртэл сар байна;

2.5.3.Зээлийн эргэн төлөлтийн эхний 12 хүртэл сарын хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлж болно;

2.5.4.Сангийн зээлийн эргэн төлөлтийн төлбөр нь сар эсхүл улирал бүр тэнцүү байна;

2.5.5.Сангаас олгох зээлийн доод хязгаар:

Ангилал	Хоршоо	ЖДҮҮЭ
Аймгийн төвийн сум	50.0 сая төгрөг	20.0 сая төгрөг
Бусад сум	30.0 сая төгрөг	15.0 сая төгрөг

2.6.Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол зээлийн үлдэгдлээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги ногдуулах нөхцөлийг сумын Засаг дарга, зээлдэгч нарын хооронд байгуулах гэрээнд заавал тусгана.

2.7. Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 30 хүртэл хувийг–хоршоо, ЖДҮҮЭ-д мэргэжил арга зүйн дэмжлэг болон сургалт, зөвлөх үйлчилгээ, борлуулалтыг дэмжих үйл ажиллагаанд, 20 хүртэл хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон программ хангамжийн зардалд, 10 хүртэл хувийг аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллагын саналыг харгалзан сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг урамшуулахад зориулан хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж болно.

2.8. Энэ журмын 1.5, 2.7-д зааснаас бусад зориулалтаар сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг нөхөн төлөх зэргээр зарцуулахыг хориглоно.

2.9. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулахтай холбоотой шимтгэл, хураамж авахыг хориглоно.

2.10. Төсөл сонгон шалгаруулах товыг зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд тухайн сумын Төсөл сонгон шалгаруулах хороо тогтооно.

2.11. Төсөл хүлээн авах хугацааг тухайн сумын иргэдэд мэдэгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.

2.12. Төсөл хүлээн авах хугацаа зарлагдахаас бусад үед төсөл хүлээн авахгүй.

2.13. Энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан хоршооны хувьд тухайн сумын хамгийн олон гишүүнтэй, үйл ажиллагааны чиглэл давхардаагүй нэг хоршоог тэргүүн ээлжид дэмжинэ.

ГУРАВ. САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх бөгөөд дараах бүрэн эрхтэй:

3.1.1. Сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг төрөөс хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

3.1.2. Сангаас олгох зээлийн болон барьцааны гэрээний загвар, маягыг батлах;

3.1.3. Сангаас олгосон зээлийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийг бүрдүүлэн хөтлөх, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд нэгтгэхтэй холбоотой дотоод журам батлах;

3.1.4. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, энэ журмын 7.1-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд сангийн дансны зарлагын гүйлгээг түр хугацаанд хааж, сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэх саналыг төсөв, санхүүгийн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.1.5. Хоршоо, ЖДҮҮЭ-д мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэх, сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, сургалт, борлуулалтыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.2. Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг дарга, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хариуцсан байгууллага хэрэгжүүлнэ:

3.2.1. Аймгийн засаг дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.а. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

3.2.1.б. Сангийн хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэх;

3.2.1.в. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.2.2. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хариуцсан байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.2.а. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороо байгуулах;

3.2.2.б. Сангаас олгосон зээлийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийг бүрдүүлэн хөтөлж, хяналтын зөвлөлөөс ирүүлсэн тайлан, мэдээг нэгтгэн хянаж, баталгаажуулах, тэдгээрийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

3.2.2.в. Орон нутагт хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон сумын Засаг даргатай хамтран сургалт, борлуулалтыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2.2.г. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.3. Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. Сангийн орлого, зарлага, төсөв болон зээлийн дээд хэмжээг энэ журмын 2.5.5-д заасан хязгаарыг баримтлан батлах;

3.3.2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулах;

3.3.3. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх;

3.3.4. Хууль тогтоомж болон Засгийн газрын бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан, зээл олгох салбар, чиглэл зэргийг батлах;

3.3.5. Батлагдсан төсвийн 40 хүртэл хувийг ахуйн үйлчилгээний салбарыг дэмжихэд зарцуулах;

3.3.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.4. Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд сумын хоршоо, ЖДҮҮЭ-ийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;

3.4.2. Төслийн нарийвчилсан судалгааг хийх гурав хүртэл хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулах, удирдлагаар хангах;

3.4.3. Төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих;

3.4.4. Зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах, үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх бөгөөд эсхүл үнэлгээний мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргах;

3.4.5. Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх;

3.4.6. Сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

3.4.7. Сангаас олгосон зээлийн тухайн жилийн хүүгийн орлогыг энэ журмын 1.5, 2.7-д заасны дагуу зарцуулах саналаа боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

3.4.8. Сангийн үйл ажиллагааны үр дүнг энэ журмын 3.2, 3.3-т заасан байгууллагын өмнө хариуцах;

3.4.9. Хоршоо, ЖДҮҮЭ-д үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болон бусад шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

саналаа жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлэн, хамтран сургалт зохион байгуулах;

3.4.10.Сангаас олгосон зээлийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийг хөтөлж тайлан, мэдээг хянах, баталгаажуулах, тэдгээрийг тогтоосон хугацаанд хүргүүлэх;

3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ;

3.4.12.Сумын хоршоо жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Монголбанкны зээлийн мэдээллийн санд илгээх мэдээллийг Сангийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн эргэн төлөлтийн баримтаар баталгаажуулан аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнд илгээж хянуулна.

ДӨРӨВ.ХОРОО БОЛОН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Хороо болон хяналтын зөвлөл тус бүр нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдсэн зургаан хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн нарийн бичгийн даргаас бусад гишүүдийг давхардуулан ажиллуулахгүй.

4.2.Хорооны даргаар тухайн аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагын хоршооны асуудал хариуцсан нэгжийн дарга, гишүүдээр аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагын жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга, хоршоо, ЖДҮҮЭ-ийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны хоёр төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна. Дээрх шаардлагыг хангах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо байхгүй тохиолдолд хоёр иргэнийг хорооны гишүүнээр ажиллуулж болно.

4.3.Хяналтын зөвлөлийн даргаар тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, гишүүдээр төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны хоёр төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн дарга нь сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

4.4.Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, иргэнийг төлөөлөх хорооны гишүүн дараах шаардлагыг хангасан байна.

4.4.1.Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

4.4.2.Сүүлийн хоёр жилд Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан албан тушаал хашиж байгаагүй, суманд үйл ажиллагаа явуулдаг байх;

4.4.3.Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

4.5.Хороо болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дарга, гишүүд нь тус бүр саналын нэг эрхтэй, нарийн бичгийн дарга саналын эрхгүй байна.

4.6.Хорооны хуралдаанд саналын эрх бүхий дөрөв болон түүнээс дээш гишүүн оролцсоноор хүчинтэйд тооцогдох ба хуралдааны явцыг дуу хураагуур, дүрс бичлэгт буулган хадгалж, хуралдааны тэмдэглэл хөтөлж хадгална. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах ба санал тэнцсэн тохиолдолд хорооны даргын саналаар эцэслэн шийдвэрлэнэ.

4.7.Хороо нь өөрийн хуралдааны дэгийг батлах бөгөөд хуралдааны тэмдэглэлд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

4.8.Хорооны төсөл сонгон шалгаруулсан шийдвэр нь тухайн төсвийн жилдээ хүчин төгөлдөр байна.

4.9.Сумын жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, нарийвчилсан судалгаа хийх ажлын хэсэг, хороо, хяналтын зөвлөл нь дараах үүрэгтэй:

4.9.1.Төслийг судлах болон төслийн хэрэгжилттэй танилцах явцад олж авсан мэдээлэл, баримт бичиг, хурлын шийдвэрийн талаар бусдад задруулахгүй байх;

4.9.2.Энэ журмын 4.9.1-т заасан мэдээлэл, сонгон шалгаруулалтад ирүүлсэн төслийг хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхолд үйлчлэх зорилгоор ашиглахгүй байх;

4.9.3.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид журам зөрчиж, давуу байдал бий болгохгүй байх;

4.9.4.Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төсөл сонгон шалгаруулах, хяналт тавих үйл ажиллагаанд оролцох бүрд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдлийг гаргах, албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл бүрт албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж энэ тухай хорооны болон хяналтын зөвлөлийн даргад бичгээр мэдэгдэх.

4.10.Сумын жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, нарийвчилсан судалгаа хийх ажлын хэсэг, хороо нь өөрийн судалсан төсөлд өгсөн үнэлгээг бүрэн хариуцна.

4.11.Энэ журмын 4.2, 4.3-т заасан шаардлагыг хангасан төрийн бус байгууллага тухайн аймаг, суманд байхгүй тохиолдолд сумын

иргэдийн олонхын үзэл бодлыг төлөөлөх чадвар бүхий иргэнийг ажиллуулж болно.

ТАВ.ЗЭЭЛД ХАМРАГДАХ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1.Төсөл нь хэрэгжүүлэгчийн мэдээлэл, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд эхлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт сайжруулалт, дуусгавар болох хугацааг тодорхой заасан байна.

5.2.Төсөл хэрэгжүүлэгчийн тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.2.1.Төслийн товч агуулга;

5.2.2.Хуулийн этгээдийн нэр;

5.2.3.а.Үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй хаяг байршил;

5.2.3.б.Хуулийн этгээдийн албан ёсны хаяг;

5.2.3.в.Төсөл хэрэгжих байршил.

5.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагааны тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.3.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны технологийн ажиллагаа;

5.3.2.Түүхий эдийн чанарын үзүүлэлт, нөөц;

5.3.3.Үйлдвэрлэлийн хүчин чадал;

5.3.4.Хэрэгжүүлэх төсөлд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт.

5.4.Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

5.4.1.Даргын иргэний үнэмлэхийн хуулбар;

5.4.2.Бүтэц, орон тоо;

5.4.3.Ажиллагсдын мэргэжил, мэргэшил, ур чадвар;

5.4.4.Шинээр бий болгох болон хадгалах ажлын байрны тоо.

5.5.Төсөлд дараах материалуудыг хавсаргасан байна:

5.5.1.Зээлийн хүсэлт;

5.5.2.Төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалд хамрагдах тооцоо;

5.5.3.Хөрөнгө оруулалтын тооцоо (өөрийн хөрөнгө оруулалтын хэмжээ, зээлийн зарцуулалтын тооцоо);

5.5.4.Төслийн өгөөж, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа;

5.5.5.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, хоршооны тухай хуульд заасны дагуу хоршоодын холбоонд элсэж

тодорхойлолт авсан байх;

5.5.6.Хуулийн этгээдийн хаягийн тодорхойлолт, дэлгэрэнгүй лавлагаа;

5.5.7.Барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон зээмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар;

5.5.8.Хэрэв зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны баталгаажсан хуулга, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн хуулбар;

5.5.9.Сүүлийн жилийн санхүүгийн баталгаажсан тайлан;

5.5.10.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тухайн жилийн тодорхойлолт;

5.5.11.Нийгмийн даатгалд хамруулсан ажилтны тоо, төлж байгаа шимтгэлийн хэмжээ болон нийгмийн даатгалын байгууллагад төсөл илгээх сүүлийн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;

5.5.12.Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт;

5.5.13.Төлсөн татварын хэмжээ болон төсөл илгээх сүүлийн өдрийн байдлаар татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх харьяа татварын албаны тодорхойлолт;

5.5.14.Тухайн төсөл болон зээлдэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, холбогдох төрийн байгууллагаас мэдээлэл авах, цуглуулах, ашиглахыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл;

5.5.15.Төсөл бүрэн хэрэгжүүлэх баталгаа.

6.6.Төсөл, түүнд хавсаргасан материалын үнэн зөв байдлыг төсөл ирүүлэгч хоршоо, ЖДҮҮЭ бүрэн хариуцна.

ЗУРГАА.САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН САНАЛ ХҮЛЭЭН АВАХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ

6.1.Хоршоо, ЖДҮҮЭ нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн талаарх саналаа тогтоосон хугацаанд энэ журмын 3.2.2-т заасан хороонд хүргүүлнэ.

6.2.Хороо нь төслийг хоршоо болон ЖДҮҮЭ-ийг онооны нийлбэрээр ихээс бага руу эрэмбэлэн тэргүүн ээлжид хоршоонд, эх үүсвэр үлдвэл ЖДҮҮЭ-д олгохоор зээлийн эх үүсвэрт багтаан жагсаалтыг батална.

6.3.Сангаас зээл авах хүсэлт ирүүлсэн хоршоо, ЖДҮҮЭ нь дараах шаардлагыг хангасан байна:

6.3.1.Тухайн суманд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг байх;

6.3.2.Монголбанкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн

зээлийн өргүй байх;

6.3.3.Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх;

6.3.4.Хоршоолох үйл ажиллагаа болон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх.

6.4.Энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан хоршоо, ЖДҮҮЭ-ийн боловсруулсан төсөл дараах нийтлэг шалгуурыг хангасан байна:

6.4.1.Тухайн суманд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн нөөцөд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх;

6.4.2.Төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой байх;

6.4.3.Гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх;

6.4.4.Төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

6.4.5.Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх;

6.4.6.Ажлын байр хадгалж, нэмэгдүүлэхэд чиглэсэн байх;

6.4.7.Хоршооны гишүүнчлэлийг хадгалж, нэмэгдүүлсэн байх;

6.4.8.Хоршооны гишүүдийн оролцоог тусгасан байх.

6.5.Зээл авахаар хүсэлт ирүүлсэн хоршоо, ЖДҮҮЭ нь бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, хороо нь төсөл сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулна.

6.6.Сангаас олгох зээлийн төсөл сонгон шалгаруулалтыг 3 үе шаттайгаар үнэлнэ.

6.6.1.Сумын жижиг, дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн нь тухайн төслийн иж бүрдэл хангасан эсэхийг шалгаж, иж бүрдлийг хангасан бол төслийн урьдчилсан судалгааг хийж 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлнэ;

6.6.2.Төсөлд нарийвчилсан судалгааг тухайн сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг хорооны шатанд шилжүүлнэ;

6.6.3.Төсөл сонгон шалгаруулах хороо нь хурлаар хэлэлцэж гишүүн тус бүр төслийг 100 хүртэл оноогоор дүгнэн, гишүүдийн дундаж оноог гарган, 3 шатны нийлбэр оноог ихээс бага руу эрэмбэлсэн жагсаалтыг энэ журмын 6.2-т заасны дагуу баталж, шийдвэрийг ажлын 3 хоногийн дотор тухайн сумын Засаг даргад хүргүүлнэ.

6.7.Төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрийг тухайн сумын

Засаг дарга хүлээн авч баталгаажуулан, эрэмбэлсэн жагсаалтын дагуу санхүүжүүлнэ.

6.8.Сумын Засаг дарга төсөл хэрэгжүүлэгчтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулна. Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн санхүүжилтийг төсөл хэрэгжүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

6.9.Сангаас зээл авсан хоршоо, ЖДҮҮЭ нь зээлийн эрсдэлийн болон хөрөнгийн даатгалд жил бүр заавал даатгуулна. Авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө.

6.10.Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална:

6.10.1.Энэ журмын 5.1-д заасан төсөл, 5.5-д заасан баримтууд;

6.10.2.Хорооны шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад;

6.10.3.Зээлийн болон барьцааны гэрээ;

6.10.4.Барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримтыг хавсаргана;

6.10.5.Зээлийн эргэн төлөлтийн хуваарь, санхүүжилт шилжүүлсэн хуулга;

6.10.6.Холбогдох бусад баримт бичиг.

6.11.Сумын Засаг дарга энэ журмын 6.10-д зааснаас гадна төслийн хэрэгжилтийн явцын талаарх хяналтын зөвлөлийн тайлан, үр дүнгийн талаарх бусад мэдээллийг тухай бүр баримтжуулан хадгалж, цахим архив үүсгэнэ.

ДОЛОО.САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ

7.1.Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Зохистой харьцаа (жилээр)
1	Зээлийн эргэн төлөлт	Нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байх
2	Чанаргүй зээлийн хэмжээ	Нийт хөрөнгийн 10 хувиас бага байх
3	Хяналт тавих үйл ажиллагаа	Жилд 2-оос доошгүй удаа
4	Олон нийтэд тайлагнасан байх	Жилд 1-ээс дээш
5	Тайлан, мэдээ	Улирал бүр
6	Ажлын байр нэмэгдүүлсэн байх	Зээлийн 50 сая төгрөг тутамд нэгээс доошгүй ажлын байр шинээр бий болгосон байх

7.2.Сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй байна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналтын зөвлөл хяналт тавина.

7.3.Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна.

7.4.Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.4.1.Зээл авсан хоршооны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан, дансны мэдээллийг гаргуулан авах;

7.4.2.Сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ;

7.4.3.Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх.

7.5.Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг улирлаар, тайланг жилээр тус тус гаргаж, улирлын мэдээг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

7.6.Аймгийн Засаг дарга энэ журмын 7.5-т заасан жилийн тайланг нэгтгэн дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.7.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 7.6-д заасан тайланг нэгтгэн, мөн журмын 7.9-д заасан аудитын дүгнэлтийн хамт тухайн жилийн I улиралд багтаан Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.8.Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын гүйцэтгэлд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, нэгдсэн аудитын дүгнэлтийг тухайн

аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүгнэлтийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

7.9.Зээлдэгч нь төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг гэрээний үүргийн дагуу төлж, төслийн талаарх тайланг жилд нэг удаа сумын иргэд, олон нийтэд тайлагнана.

7.10.Хоршоо, ЖДҮҮЭ нь сумын иргэдийн хоршиж хөдөлмөрлөх идэвх санаачилгыг дэмжих, шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалах, эрүүл, аюулгүй хүнс, үйлчилгээгээр хангах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үүрэг хүлээнэ.

НАЙМ.ИЛ ТОД БАЙДАЛ

8.1.Төсөл сонгон шалгаруулалтад шалгараагүй төслүүдийн баримт бичгийг үндэслэл, тайлбарын хамт төсөл ирүүлэгчид буцаана.

8.2.Хорооны хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан шалгарсан зээлдэгчийн мэдээллийг аймаг, сумын Засаг дарга цахим хуудсаараа дамжуулан мэдээлнэ.

8.3.Зээлдэгчийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ.

ЕС.ЗЭЭЛДЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

9.1.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчийн холбогдох мэдээллийг агуулсан Зээлийн мэдээллийн нэгдсэн санг хөтөлнө.

9.2.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлийн ангиллыг тогтоохдоо Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд нарын хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг баримтална.

9.3.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ.

АРАВ.ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

10.1.Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.

10.2.Эргэн төлөлтийн хуваарь нь нийт төлбөр тэнцүү тооцох аргачлалаар үндсэн зээл болон хүүгийн нийт төлбөрийн дүн сар бүр

тэнцүү дүнтэй байна.

10.3.Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монголбанкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ.

10.4.Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна.

АРВАН НЭГ.ХАРИУЦЛАГА

11.1.Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж сангийн хохирлыг барагдуулна.

11.2.Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/191

Улаанбаатар
хот

ЖАГСААЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан импортын мэдэгдэл олгох амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан жагсаалтыг үйл ажиллгандаа мөрдүүлж, холбогдох чиглэлийн албан хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газар (Б.Батсүх), Ургамал хамгааллын газар (Э.Уламбаатар)-т тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Батшагай)-т, тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар (Г.Батзориг)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/571 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД

Ц.ИДЭРБАТ

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт

ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ТҮВШИНГ ХАРГАЛЗАН ИМПОРТЫН МЭДЭГДЭЛ ОЛГОХ АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

Д/д	БТКУС код	Барааны нэр төрлийн ангилал ба монгол тодорхойлолт	Хэмжих нэгж
1	01.01	Амьд адуу, илжиг, луус болон хөдий луус	толгой
2	0101.20.00	Адуу	толгой
3	0101.21.00	Цэвэр үүлдрийн үржлийн адуу	толгой
4	0101.29.00	Бусад /Цэвэр үүлдрийн үржлийн бус адуу/	толгой
5	0101.30.00	Илжиг	толгой
6	0101.90.00	Луус, хөдий луус	толгой
7	01.02	Амьд үхэр	толгой
8	0102.20.00	Үхэр	толгой
9	0102.21.00	Цэвэр үүлдрийн үржлийн үхэр	толгой
10	0102.21.10	Үхэр, бух, шар	толгой
11	0102.21.20	Сарлаг	толгой
12	0102.29.00	Бусад /үхэр, одос үхэрнээс бусад үхэр/	толгой
13	0102.29.10	Үхэр, бух, шар	толгой
14	0102.29.20	Одос үхэр	толгой
15	0102.31.00	Цэвэр үүлдрийн үржлийн ордос үхэр	толгой
16	0102.39.00	Бусад /Цэвэр үүлдрийн үржлийн бус ордос үхэр/	толгой
17	01.03	Амьд гахай	толгой
18	0103.10.00	Цэвэр үүлдрийн үржлийн гахай	толгой
19	0103.91.00	Цэвэр үүлдрийн үржлийн бус гахай 50 кг-аас бага жинтэй	толгой
20	0103.92.00	Цэвэр үүлдрийн үржлийн бус гахай 50 кг эсвэл түүнээс их жинтэй	толгой
21	01.04	Амьд хонь, ямаа	толгой
22	0104.10.00	Хонь	толгой
23	0104.20.00	Ямаа	толгой
24	01.05	Тэжээвэр амьд шувуу, тухайлбал Gallus domesticus төрлийн тахиа, нугас, галуу, цацагт хяруул болон сувд гургуул	толгой
25	0105.10.00	185 гр-аас ихгүй жинтэй	толгой
26	0105.11.00	Gallus domesticus төрлийн тахиа	толгой
27	0105.12.00	Цацагт хяруул	толгой
28	0105.13.00	Нугас	толгой
29	0105.14.00	Галуу	толгой
30	0105.15.00	Сувд гургуул	толгой

31	0105.90.00	Бусад	толгой
32	0105.94.00	Gallus domesticus төрлийн тахиа	толгой
33	0105.99.00	Цацагт хяруул, нугас, галуу, сувд гургуул болон бусад тэжээвэр амьд шувуу	толгой
34	01.06	Бусад амьд мал, амьтан	толгой
35	0106.10.00	Хөхтөн амьтан	толгой
36	0106.11.00	Мич төрөлтөн	толгой
37	0106.12.00	Халим, дельфин болон далайн гахай (Cetacea төрлийн хөхтөн); далайн үхэр болон дугаанг (Sirenia төрлийн хөхтөн); далайн хав, далайн арслан болон далайн морь (Pinnipediагийн дэд төрлийн хөхтөн)	толгой
38	0106.13.00	Тэмээ болон бусад тэмээн төрөлхтөн (Camelidia)	толгой
39	0106.14.00	Туулай болон молтогчин туулай	толгой
40	0106.19.00	Мич төрөлтөн; Халим, дельфин болон далайн гахай (Cetacea төрлийн хөхтөн); далайн үхэр болон дугаанг (Sirenia төрлийн хөхтөн); далайн хав, далайн арслан болон далайн морь (Pinnipediагийн дэд төрлийн хөхтөн); Тэмээ болон бусад тэмээн төрөлхтөн (Camelidia); Туулай болон молтогчин туулай -аас бусад хөхтөн амьтан	толгой
41	0106.20.00	Хэвлээр явагч амьтан (могой болон яст мэлхий орно)	толгой
42	0106.30.00	Шувуу	толгой
43	0106.31.00	Махчин шувуу	
44	0106.31.10	Идлэг шонхор	толгой
45	0106.31.90	Идлэг шонхороос бусад шувуу	толгой
46	0106.32.00	Тотьтоны баг (parrots, parakeets, macaws, cockatoos)	толгой
47	0106.33.00	Тэмээн хяруул; тэмээн хяруул /Австралийн урт хөлт, нисдэггүй том шувуу (Dromaius novaehollandiae)	толгой
48	0106.39.00	Идлэг шонхор; Тотьтоны баг; Тэмээн хяруул зэргээс бусад шувуу	толгой
49	0106.40.00	Шавж	ширхэг
50	0106.41.00	Зөгий	ширхэг
51	0106.49.00	Зөгийнөөс бусад шавж	ширхэг
52	0106.90.00	Хөхтөн амьтан; Хэвлээр явагч амьтан; Шувуу; Шавжаас бусад амьд амьтан	толгой
53	02.01	Үхрийн шинэ эсвэл хөргөсөн мах	кг
54	0201.10.00	Үхрийн гулууз болон өрөөл	кг
55	0201.20.00	Үхрийн ястай нь хэсэглэсэн бусад мах	кг
56	0201.20.10	Үхрийн	кг
57	0201.20.20	Сарлагийн	кг
58	0201.30.00	Үхрийн ясгүй мах	кг
59	0201.30.10	Үхрийн	кг
60	0201.30.20	Сарлагийн	кг
61	02.02	Үхрийн хөлдүү мах	кг
62	0202.10.00	Үхрийн гулууз болон өрөөл мах	кг

63	0202.20.00	Үхрийн ястай нь хэсэглэсэн бусад мах	кг
64	0202.20.10	Үхрийн	кг
65	0202.30.20	Сарлагийн	кг
66	0202.30.00	Үхрийн ясгүй мах	кг
67	0202.30.10	Үхрийн	кг
68	0202.30.20	Сарлагийн	кг
69	02.03	Гахайн шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах	кг
70	0203.10.00	Гахайн шинэ эсвэл хөргөсөн мах	кг
71	0203.11.00	Гахайн гулууз болон өрөөл мах	кг
72	0203.12.00	Гахайн гуя, хаа болон тэдгээрийн ястай нь хэсэглэсэн мах	кг
73	0203.19.00	Гахайн гулууз болон өрөөл, гуя, хаа болон тэдгээрийн ястай нь хэсэглэснээс бусад мах	кг
74	0203.20.00	Гахайн хөлдүү мах	кг
75	0203.21.00	Гахайн хөлдүү гулууз болон өрөөл мах	кг
76	0203.22.00	Гахайн хөлдүү гуя, хаа болон тэдгээрийн ястай нь хэсэглэсэн мах	кг
77	0203.29.00	Гахайн хөлдөө гулууз болон өрөөл, гуя, хаа болон тэдгээрийн ястай нь хэсэглэснээс бусад мах	кг
78	02.04	Хонь, ямааны шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах	кг
79	0204.10.00	Хурганы шинэ эсвэл хөргөсөн гулууз болон өрөөл мах	кг
80	0204.20.00	Хонины шинэ эсвэл хөргөсөн мах	кг
81	0204.21.00	Хонины шинэ эсвэл хөргөсөн гулууз болон өрөөл мах	кг
82	0204.22.00	Хонины шинэ эсвэл хөргөсөн ястай нь хэсэглэсэн мах	кг
83	0204.23.00	Хонины шинэ эсвэл хөргөсөн ясгүй мах	кг
84	0204.30.00	Хурганы хөлдүү гулууз болон өрөөл мах	кг
85	0204.40.00	Хонины шинэ биш эсвэл хөргөөгүй мах	кг
86	0204.41.00	Хонины шинэ биш эсвэл хөргөөгүй гулууз болон өрөөл мах	кг
87	0204.42.00	Хонины шинэ биш эсвэл хөргөөгүй ястай бусад хэсэг	кг
88	0204.43.00	Хонины шинэ биш эсвэл хөргөөгүй ясгүй мах	кг
89	0204.50.00	Ямааны мах	кг
90	0205.00.00	Адууны мах	кг
91	0205.00.11	Ястай	кг
92	0205.00.12	Ясгүй /шулсан/	кг
93	0205.00.90	Илжиг, луус эсвэл хөдий луусын мах	кг
94	02.06	Үхэр, гахай, хонь, ямаа, адуу, илжиг, луус эсвэл хөдий луусын шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү хүнсний дайвар мах	кг
95	0206.10.00	Үхрийн шинэ эсвэл хөргөсөн хүнсний дайвар мах	кг
96	0206.20.00	Үхрийн шинэ эсвэл хөргөсөн хөлдүү хүнсний дайвар мах	кг
97	0206.21.00	Үхрийн шинэ эсвэл хөргөсөн хөлдүү хэл	кг
98	0206.22.00	Үхрийн шинэ эсвэл хөргөсөн хөлдүү элэг	кг
99	0206.29.00	Бусад	кг

100	0206.30.00	Гахайн шинэ эсвэл хөргөсөн мах хүнсний дайвар мах	кг
101	0206.40.00	Гахайн хөлдүү хүнсний дайвар мах	
102	0206.41.00	Гахайн элэг	кг
103	0206.49.00	Гахайн хөлдүү элэгнээс бусад хүнсний дайвар мах	кг
104	0206.80.00	Шинэ эсвэл хөргөсөн хонь, ямаа, адуу, илжиг, луус эсвэл хөдий луусын шинэ, хөргөсөн хүнсний дайвар мах	кг
105	0206.90.00	Хөлдүү бусад	кг
106	0206.90.10	Хонины эсвэл ямааны хөлдүү хүнсний дайвар мах	кг
107	0206.90.20	Адууны хөлдүү хүнсний дайвар мах	кг
108	0206.90.90	Үхэр, гахай, ямаа, илжиг, луус эсвэл хөдий луусын хөлдүү хүнсний дайвар мах	кг
109	02.07	Зүйл 0105-д Заасан тэжээвэр шувууны шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
110	0207.10.00	Gallus domesticus төрлийн тахианы шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
111	0207.11.00	Gallus domesticus төрлийн тахианы шинэ эсвэл хөргөсөн, бүтэн мах	кг
112	0207.12.00	Gallus domesticus төрлийн тахианы хөлдүү бүтэн мах	кг
113	0207.13.00	Gallus domesticus төрлийн тахианы шинэ эсвэл хөргөсөн, хэсэглэсэн мах болон дайвар мах	кг
114	0207.14.00	Gallus domesticus төрлийн тахианы хөлдүү, хэсэглэсэн мах болон дайвар мах	кг
115	0207.20.00	Цацагт хяруулын шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
116	0207.24.00	Цацагт хяруулын шинэ эсвэл хөргөсөн, бүтэн мах	кг
117	0207.25.00	Цацагт хяруулын хөлдүү бүтэн мах	кг
118	0207.26.00	Цацагт хяруулын шинэ эсвэл хөргөсөн, хэсэглэсэн мах болон дайвар мах	кг
119	0207.27.00	Цацагт хяруулын хөлдүү, хэсэглэсэн мах болон дайвар мах	кг
120	0207.40.00	Нугасны шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
121	0207.41.00	Нугасны хэсэглээгүй бүтэн мах (шинэ эсвэл хөргөсөн)	кг
122	0207.42.00	Нугасны хэсэглээгүй бүтэн мах (хөлдөөсөн)	кг
123	0207.43.00	Нугасны өөхтэй элэг (шинэ эсвэл хөргөсөн)	кг
124	0207.44.00	Нугасны хэсэглэсэн мах болон өөхтэй элэгнээс бусад хүнсний дайвар мах (шинэ эсвэл хөргөсөн)	кг
125	0207.45.00	Нугасны хэсэглэсэн мах болон өөхтэй элэгнээс бусад хүнсний дайвар мах (хөлдөөсөн)	кг
126	0207.50.00	Галууны шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
127	0207.51.00	Галууны хэсэглээгүй бүтэн мах (шинэ эсвэл хөргөсөн)	кг
128	0207.52.00	Галууны хэсэглээгүй бүтэн мах (хөлдөөсөн)	кг
129	0207.53.00	Галууны өөхтэй элэг (шинэ эсвэл хөргөсөн)	кг

130	0207.54.00	Галууны хэсэглэсэн мах болон өөхтэй элэгнээс бусад хүнсний дайвар мах (шинэ эсвэл хөргөсөн)	кг
131	0207.55.00	Галууны хэсэглэсэн мах болон өөхтэй элэгнээс бусад хүнсний дайвар мах (хөлдөөсөн)	кг
132	0207.60.00	Сувд гургуулын шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
133	02.08	Шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
134	0208.10.00	Туулай эсвэл молтогчингийн мах	кг
135	0208.30.00	Мич төрөлтний мах	кг
136	0208.40.00	Халим, дельфин болон далайн гахай (Cetacea төрлийн хөхтөн амьтан)-н; далайн Үхэр болон (Sirenia төрлийн хөхтөн амьтан)-ийн; далайн хав, далайн арслан болон далайн морь (Pinnipediaгийн дэд төрлийн хөхтөн амьтан)-ны мах	кг
137	0208.50.00	Хэвлээр явагч амьтан (могой болон яст мэлхий орно)-ын мах	кг
138	0208.60.00	Тэмээний болон бусад тэмээн төрөлтөн (Camelidia) амьтны мах	кг
139	0208.90.00	Бусад амьтдын шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах болон хүнсний дайвар мах	кг
140	0208.90.20	Ангийн мах	кг
141	0208.90.90	Ангийнхаас бусад мах	кг
142	02.09	Гахай, шувууны хайлмал биш эсвэл бусад аргаар гаргаж аваагүй, шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, эсвэл утсан даан өөх	кг
143	0209.10.00	Гахайн хайлмал биш эсвэл бусад аргаар гаргаж аваагүй, шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, эсвэл утсан даан өөх	кг
144	0209.90.00	Шувууны хайлмал биш эсвэл бусад аргаар гаргаж аваагүй, шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, эсвэл утсан даан өөх	кг
145	02.10	Давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан мах болон хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
146	0210.10.00	Гахайн давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан мах	кг
147	0210.11.00	Гахайн давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан гуя, хаа болон тэдгээрийн ястай хэсэглэсэн мах	кг
148	0210.12.00	Гахайн давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан өвчүү болон тэдгээрийн хэсэг	кг
149	0210.19.00	Гахайн давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
150	0210.20.00	Үхрийн давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан мах	кг

151	0210.90.00	Үхрийн давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
152	0210.91.00	Мич төрөлтний давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
153	0210.92.00	Халим, дельфин болон далайн гахай (Cetacea төрлийн хөхтөн амьтан)-н; далайн Үхэр болон (Sirenia төрлийн хөхтөн амьтан)-ийн; далайн хав, далайн арслан болон далайн морь (Pinnipediaгийн дэд төрлийн хөхтөн амьтан)-ны давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
154	0210.93.00	Хэвлээр явагч амьтан (могой болон яст мэлхий орно)-ын давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
155	0210.99.00	Гахай; шувуу; Үхэр; мич төрөлтөн; халим, дельфин болон далайн гахай (Cetacea төрлийн хөхтөн амьтан)-н; далайн үхэр болон (Sirenia төрлийн хөхтөн амьтан)-ийн; далайн хав, далайн арслан болон далайн морь (Pinnipediaгийн дэд төрлийн хөхтөн амьтан), хэвлээр явагч амьтан (могой болон яст мэлхий орно)-ны давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан эсвэл утсан хүнсний дайвар мах; мах, дайвар махны хүнсний гурил болон буталмал	кг
156	03.01	Амьд загас	толгой
157	0301.10.00	Гоёл чимэглэлийн (үзмэрийн) амьд загас	толгой
158	0301.11.00	Цэнгэг усны амьд загас	кг
159	0301.19.00	Цэнгэг бус усны амьд загас	кг
160	0301.90.00	Гоёл чимэглэлийн (үзмэрийн)-ээс бусад амьд загас	Тоо толгой
161	0301.91.00	Тулбага загас (<i>Salmo trutta</i> , <i>Oncorhynchus mykiss</i> , <i>Oncorhynchus clarki</i> , <i>Oncorhynchus aguabonita</i> , <i>Oncorhynchus gilae</i> , <i>Oncorhynchus apache</i> , <i>Oncorhynchus chrysogaster</i>)	кг
162	0301.92.00	Могой загас (<i>Anguilla</i> spp)	кг
163	0301.93.00	Мөрөг Загас (<i>Cyprinus carpio</i> , <i>Carassius carassius</i> , <i>Stenopharyngodon idellus</i> , <i>Hypophthalmichthys</i> spp, <i>Cirrhinus</i> spp, <i>Mylopharyngodon piceus</i>)	кг
164	0301.94.00	Атлантын болон Номхон далайн хөх сэлүүрт туна загас (<i>Thunnus thynnus</i> , <i>Thunnus orientalis</i>)	кг
165	0301.95.00	Өмнө зүгийн хөх сэрвээт туна загас (<i>Thunnus maccoyii</i>)	кг
166	0301.99.00	Бусад амьд загас	кг
167	03.02	Шинэ эсвэл хөргөсөн загас (зүйл 0304-т заасан загасны ясгүй гол мах болон бусад мах орохгүй)	кг
168	0302.10.00	Хулд төрлийн загас (элэг, түрс орохгүй)	кг

169	0302.11.00	Тулбара загас (<i>Salmo trutta</i> , <i>Oncorhynchus mykiss</i> , <i>Oncorhynchus clarki</i> , <i>Oncorhynchus aguabonita</i> , <i>Oncorhynchus gilae</i> , <i>Oncorhynchus apache</i> , <i>Oncorhynchus chrysogaster</i>)	кг
170	0302.13.00	Номхон далайн хулд (<i>Oncorhynchus nerka</i> , <i>Oncorhynchus gorbusha</i> , <i>Oncorhynchus keta</i> , <i>Oncorhynchus kisutch</i> , <i>Oncorhynchus masou</i> болон <i>Oncorhynchus rhodurus</i>)	кг
171	0302.14.00	Атлантын хулд (<i>Salmo salar</i>) болон Дунайн хулд (<i>Hucho hucho</i>)	кг
172	0302.19.00	Хулд төрлийн загас бусад загас	кг
173	0302.20.00	Хавтгай төрлийн Загас (<i>Pleuronectidae</i> , <i>Bothidae</i> , <i>Synoglossidae</i> , <i>Soleidae</i> , <i>Scophthalmidae</i> , <i>Citharidae</i>) (элэг, түрс орохгүй)	кг
174	0302.21.00	Цагаан халпий (<i>Reinhardtius hippoglossoides</i> , <i>Hippoglossus hippoglossus</i> , <i>Hippoglossus stenolepis</i>)	кг
175	0302.22.00	Далайн хальпий (<i>Pleuronectes platessa</i>)	кг
176	0302.23.00	Ул загас (<i>Solea spp</i>)	кг
177	0302.24.00	Цагаан хайрст загас (<i>Psetta maxima</i> , <i>Scophthalmidae</i>)	кг
178	0302.29.00	Хавтгай төрлийн бусад загас	кг
179	0302.30.00	Туна загас (<i>Thunnus</i>) жад загас эсвэл судалт туна (<i>Euthynnus (Katsuwonus) pelamis</i>), (элэг, түрс орохгүй)	кг
180	0302.31.00	Альбакор эсвэл урт сэлүүрт туна загас (<i>Thunnus alalunda</i>)	кг
181	0302.32.00	Шар сэлүүрт туна (<i>Thunnus albacares</i>)	кг
182	0302.33.00	Жад загас буюу судалт туна	кг
183	0302.34.00	Том нүдэт туна загас (<i>Thunnus obesus</i>)	кг
184	0302.35.00	Атлантын болон Номхон далайн хөх сэлүүрт туна Загас (<i>Thunnus thynnus</i> , <i>Thunnus orientalis</i>)	кг
185	0302.36.00	Өмнө зүгийн хөх сэлүүрт туна загас (<i>Thunnus maccoyii</i>)	кг
186	0302.39.00	Туна загас (<i>Thunnus</i>) жад загас эсвэл судалт туна (<i>Euthynnus (Katsuwonus) pelamis</i>), (элэг, түрс орохгүй)-аас бусад загас	кг
187	0302.40.00	Май загас (<i>Clupea harengus</i> , <i>Clupea pallasii</i>), анчоус загас (<i>Engraulis spp</i>), сардин Загас (<i>Sardina pilchardus</i> , <i>Sardinops spp</i>) сардинелл загас (<i>Sardinella spp</i>), хайга загас буюу шпрот (<i>Sprattus sprattus</i>), балмад загас (<i>Scomber scombrus</i> , <i>Scomber australasicus</i> , <i>Scomber japonicus</i>), морин загас (<i>Trachurus spp</i>), кобия (<i>Rachycentron canadum</i>) болон жадан хошуут загас (<i>Xiphias gladius</i>) (элэг, түрс нь орохгүй)	кг
188	0302.41.00	Май загас (<i>Clupea harengus</i> , <i>Clupea pallasii</i>)	кг
189	0302.42.00	Анчоус загас (<i>Engraulis spp</i>)	кг
190	0302.43.00	Сардин загас (<i>Sardina pilchardus</i> , <i>Sardinops spp</i>) сардинелл загас (<i>Sardinella spp</i>), хайга загас буюу шпрот (<i>Sprattus sprattus</i>)	кг

191	0302.44.00	Балмад загас (<i>Scomber scombrus</i> , <i>Scomber australasicus</i> , <i>Scomber japonicus</i>)	кг
192	0302.45.00	Морин загас (<i>Trachurus spp</i>)	кг
193	0302.46.00	Кобия (<i>Rachycentron canadum</i>)	кг
194	0302.47.00	Жадан хошуут загас (<i>Xiphias gladius</i>)	кг
195	0302.50.00	Bregmacerotidae, Euclichthyidae, Gadidae, Macrouridae, Melanonidae, Merlucciidae, Moridae болон Muraenolepididae төрлийн загас (элэг, түрс нь орохгүй)	кг
196	0302.51.00	Сагамхай загас (<i>Gadus morhua</i> , <i>Gadus ogac</i> , <i>Gadus macrocephalus</i>)	кг
197	0302.52.00	Пикша загас (<i>Melanogrammus aeglefinus</i>)	кг
198	0302.53.00	Сайда загас (<i>Pollachius virens</i>)	кг
199	0302.54.00	Хек загас (<i>Merluccius spp</i> , <i>Urophycis spp</i>)	кг
200	0302.55.00	Аляскийн поллак загас (<i>Theragra chalcogramma</i>)	кг
201	0302.56.00	Хөх мөрлан загас (<i>Micromesistius routassou</i> , <i>Micromesistius australis</i>)	кг
202	0302.59.00	Bregmacerotidae, Euclichthyidae, Gadidae, Macrouridae, Melanonidae, Merlucciidae, Moridae болон Muraenolepididae төрлийн бусад загас (элэг, түрс нь орохгүй)	кг
203	0302.70.00	Тилапия загас (<i>Oreochromis spp</i>), цулбуурт загас (<i>Pangasius spp</i> , <i>Silurus spp</i> , <i>Clarias spp</i> , <i>Ictalurus spp</i>), мөрөг Загас (<i>Cyprinus carpio</i> , <i>Carassius carassius</i> , <i>Stenopharyngodon idellus</i> , <i>Hypophthalmichthys spp</i> , <i>Cirrhinus spp</i> , <i>Mylopharyngodon piceus</i>), могой загас (<i>Anguilla spp</i>), Нил мөрний алгана загас (<i>Lates niloticus</i>) болон могой толгойт загас (<i>Channa spp</i>), (элэг, түрс нь орохгүй)	кг
204	0302.71.00	Тилапия загас (<i>Oreochromis spp</i>)	кг
205	0302.72.00	Цулбуурт загас (<i>Pangasius spp</i> , <i>Silurus spp</i> , <i>Clarias spp</i> , <i>Ictalurus spp</i>)	кг
206	0302.73.00	Мөрөг загас (<i>Cyprinus carpio</i> , <i>Carassius carassius</i> , <i>Stenopharyngodon idellus</i> , <i>Hypophthalmichthys spp</i> , <i>Cirrhinus spp</i> , <i>Mylopharyngodon piceus</i>)	кг
207	0302.74.00	Могой загас (<i>Anguilla spp</i>)	кг
208	0302.79.00	Могой толгойт загас (<i>Channa spp</i>) болон бусад загас	кг
209	0302.80.00	Бусад шинэ эсвэл хөргөсөн загас (элэг, түрс нь орохгүй)	кг
210	0302.81.00	Далайн чоно загас ба бусад аварга загас	кг
211	0302.82.00	Дэвээхэй загас (<i>Rajidae</i>)	кг
212	0302.83.00	Шүдэт загас (<i>Dissostichus spp</i>)	кг
213	0302.84.00	Далайн алгана загас (<i>Dicentrarchus spp</i>)	кг
214	0302.85.00	Далайн зоодой загас (<i>Sparidae</i>)	кг
215	0302.89.00	Бусад шинэ эсвэл хөргөсөн загас	кг
216	0302.90.00	Загасны элэг, түрс	кг

217	03.03	Хөлдүү загас (зүйл 0304-т заасан загасны ясгүй гол мах болон бусад мах орохгүй)	
218	0303.10.00	Хулд төрлийн хөлдүү загас (элэг, түрс нь орохгүй)	кг
219	0303.11.00	Хөлдүү <i>Sockeye</i> хулд (улаан хулд) (<i>Oncorhynchus nerka</i>) загас	кг
220	0303.12.00	Хөлдүү номхон далайн бусад хулд (<i>Oncorhynchus gorbusha</i> , <i>Oncorhynchus keta</i> , <i>Oncorhynchus tshawytscha</i> , <i>Oncorhynchus kisutch</i> , <i>Oncorhynchus masou</i> болон <i>Oncorhynchus rhodurus</i>) загас	кг
221	0303.13.00	Хөлдүү атлантын хулд (<i>Salmo salar</i>) болон дунайн хулд (<i>Hucho hucho</i>) загас	кг
222	0303.14.00	Хөлдүү тулбага загас (<i>Salmo trutta</i> , <i>Oncorhynchus mykiss</i> , <i>Oncorhynchus clarki</i> , <i>Oncorhynchus aguabonita</i> , <i>Oncorhynchus gilae</i> , <i>Oncorhynchus apache</i> болон <i>Oncorhynchus chrysogaster</i>) загас	кг
223	0303.19.00	Хулд төрлийн бусад хөлдүү загас	кг
224	0303.20.00	Хөлдүү Тилапия загас (<i>Oreochromis spp</i>), цулбуурт загас (<i>Pangasius spp</i> , <i>Silurus spp</i> , <i>Clarias spp</i> , <i>Ictalurus spp</i>), мөрөг загас (<i>Cyprinus carpio</i> , <i>Carassius carassius</i> , <i>Stenopharyngodon idellus</i> , <i>Hypophthalmichthys spp</i> , <i>Cirrhinus spp</i> , <i>Mylopharyngodon piceus</i>), могой загас (<i>Anguilla spp</i>), Нил мөрний алгана загас (<i>Lates niloticus</i>) болон могой толгойт загас (<i>Channa spp</i>), (элэг, түрс нь орохгүй)	
225	0303.23.00	Хөлдүү Тилапия загас (<i>Oreochromis spp</i>)	кг
226	0303.24.00	Хөлдүү цулбуурт загас (<i>Pangasius spp</i> , <i>Silurus spp</i> , <i>Clarias spp</i> , <i>Ictalurus spp</i>)	кг
227	0303.25.00	Хөлдүү Мөрөг загас (<i>Cyprinus carpio</i> , <i>Carassius carassius</i> , <i>Stenopharyngodon idellus</i> , <i>Hypophthalmichthys spp</i> , <i>Cirrhinus spp</i> , <i>Mylopharyngodon piceus</i>)	кг
228	0303.26.00	Хөлдүү могой загас (<i>Anguilla spp</i>)	кг
229	0303.29.00	Нил мөрний алгана загас (<i>Lates niloticus</i>) болон могой толгойт загас (<i>Channa spp</i>), (элэг, түрс нь орохгүй) болон бусад хөлдүү загас	кг
230	0303.30.00	Хөлдүү халлий (<i>Pleuronectidae</i> , <i>Bothidae</i> , <i>Cynoglossidae</i> , <i>Soleidae</i> , <i>Scophthalmidae</i> , <i>Citharidae</i>) төрлийн загас (элэг, түрс орохгүй)	кг
231	0303.31.00	Хөлдүү цагаан халлий загас (<i>Reinhardtius hippoglossoides</i> , <i>Hippoglossus hippoglossus</i> , <i>Hippoglossus stenolepis</i>)	кг
232	0303.32.00	Хөлдүү хальпий загас (<i>Pleuronectes platessa</i>)	кг
233	0303.33.00	Хөлдүү ул загас (<i>Solea spp</i>)	кг
234	0303.34.00	Хөлдүү цагаан хайрст загас (<i>Psetta maxima</i>)	кг
235	0303.39.00	Хөлдүү халлий төрлийн бусад загас	кг
236	0303.40.00	Хөлдүү туна (<i>Thunnus</i>) жад загас, судалт туна (<i>Euthynnus (Katsuwonus) pelamis</i>) (элэг, түрс орохгүй) загас	кг

237	0303.41.00	Хөлдүү урт сэлүүрт туна загас эсвэл альбакор (<i>Thunnus alalunda</i>) загас	кг
238	0303.42.00	Хөлдүү шар сэлүүрт туна (<i>Thunnus albacares</i>) загас	кг
239	0303.43.00	Хөлдүү пеламида эсвэл судалт туна загас	кг
240	0303.44.00	Хөлдүү том нүдэт туна загас (<i>Thunnus obesus</i>) загас	кг
Аялал жуулчлалын чиглэлээр үйл явуулж буй гэр кемп нь нутгийн малчид иргэд зөвхөн гэрээр үйлчилж буй иргэд, жуулчны бааз нь худалдаа үйлчилгээ, кофе шоп, гуанз, ресторанаар үйлчилдэг тул эрхэлж байгаа үйл ажиллагаагаар нь ялгаатай тогтоосон.

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар А/30

Улаанбаатар
хот

ЖУРАМ, ЗАГВАРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 155 дугаар зарлигийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам, загвар батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/13 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журам”-ын дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.3.Чадамжийн гэрчилгээг батлагдсан загвар 1-ийн дагуу цахим системд байршуулах бөгөөд чадамж эзэмшсэн иргэн системээс хэвлэн авч болно.”;

“5.10.Боловсролын баримт бичгийн бичвэрийг батлагдсан загварын дагуу “Arial” үсгийн фонтоор, хар өнгөөр бичнэ. Монгол бичгийн фонтыг MongolianScript фонтоор (эсвэл түүнтэй адил стандарт фонт) бичнэ.”;

“5.14.Дипломд сургалтын байгууллагын нэр, төгсөгчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, эзэмшсэн мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр, индекс, мэргэшлийн нэр, мэргэшлийн түвшин, боловсролын түвшин, элссэн огноо, төгссөн огноо, сургалтын хэлбэр, дипломын улсын бүртгэлийн дугаар, судалсан хичээлийн нэр, багц цаг, сурлагын хувьчилсан оноо ба үсгэн үнэлгээ, төгсөлтийн үнэлгээ, дипломын ажлын сэдэв, голч дүнг тэмдэглэж, төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч, сургалтын байгууллагын захирал гарын үсэг зурж, баталгаажуулна.”;

“5.15.Мэргэжлийн үнэмлэхэд сургалтын байгууллагын нэр, төгсөгчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар,

эзэмшсэн мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр, индекс, мэргэшлийн нэр, мэргэшлийн түвшин, боловсролын түвшин, сургалтын хэлбэр, ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх, сонгох чадамжийн нэгжийн нэр, гүйцэтгэлийн хувь, “чадамжтай”, “хараахан чадамж эзэмшээгүй” гэсэн үсгэн тэмдэглэгээг тус тус бичиж, төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч, сургалтын байгууллагын захирал гарын үсэг зурж баталгаажуулна.”;

“5.16.Чадамжийн гэрчилгээнд гэрчилгээний дугаар, иргэний бүртгэлийн дугаар, огноо, төгсөгчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр /код/, чадамжийн нэгжийн код, чадамжийн нэгжийн нэр, сургалтын байгууллагын нэр, мэргэшлийн түвшин, багц цаг, QR, цахим гарын үсэгтэй байна.”;

“5.17.Боловсролын баримт бичигт гарын үсгийн дардас хэрэглэхгүй бөгөөд цахим гарын үсгээр баталгаажуулна.”;

“5.24.Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн I-VI түвшинд нэг чадамжийг эзэмшсэн тохиолдолд чадамжийн гэрчилгээ олгоно. Чадамжийн нэгж нь стандартад суурилсан сургалтын хөтөлбөрийн чадамжийн сантай байна.”.

2.Мөн журмын 2, 3, 5 дугаар бүлэгт доор дурдсан агуулга бүхий 2.7, 3.7, 5.25 дахь заалт нэмсүгэй.

“2.7.Мэргэжлийн үнэмлэх, дипломыг үнэт цаасан дээр батлагдсан загвар 2, загвар 3-ын дагуу хэвлэнэ.”;

“3.7.“Чадамжийн гэрчилгээ”-г төрийн захиргааны байгууллага баталгаажуулсны дараа систем хөгжүүлэгч байгууллага нэгдсэн цахим системд байршуулна.”;

“5.25.Энэхүү журмын 5.14, 5.15-д заасны дагуу диплом, мэргэжлийн үнэмлэхэд сургалтын хэлбэрийг бичихдээ төгсөгч нь Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.1-д заасан сургалтын хэлбэрээс аль хэлбэрээр суралцсаныг сонгон тэмдэглэнэ.”.

3.Тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Чадамжийн гэрчилгээний загвар”-ыг нэгдүгээр хавсралтын дагуу, гуравдугаар хавсралтаар баталсан “Мэргэжлийн үнэмлэхийн загвар”-ыг хоёрдугаар хавсралтын дагуу, дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Дипломын загвар”-ыг гуравдугаар хавсралтын дагуу тус тус өөрчилсүгэй.

4.Энэхүү тушаалаар баталсан нэмэлт, өөрчлөлтийг 2025-2026 оны хичээлийн жилийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэгчид, 2026 оны мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчдөөс эхлэн мөрдсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын

газар (Н.Нарангэрэл), Цахим боловсрол, статистик мэдээллийн хэлтэс (Т.Бат-Эрдэнэ)-т, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, системд нэмэлт хөгжүүлэлт хийж ажиллахыг Боловсролын мэдээллийн технологийн төв (Д.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.





7.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан “Журам, загвар батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/505, А/267 дугаар тушаалыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсролын сайдын 2026 оны 04 дүгээр сарын
28-ны өдрийн А/30 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

Загвар 1: Чадамжийн гэрчилгээний загвар


 БОЛОВСРОЛЫН ЯАМ	 ЗАСГИЙН ГАРЫН ХЭРГЭЖүүлэгч АГЕНТЛЭГ БОЛОВСРОЛЫН ЕРӨНЖИЙ ГАЗАР	
<h1>ЧАДАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ</h1>		
Дугаар:	Иргэний бүртгэлийн дугаар:	Огноо:
Эцэг эхийн нэр Өөрийн нэр		
Мэргэжлийн чиглэл/Хөтөлбөрийн нэр /код/:		
Чадамжийн нэгжийн код: Чадамжийн нэгжийн нэр:		
Сурвалтын байгууллагын нэр		
Мэргэшлийн түвшин:	Баец цаг:	
		
Гэрчилгээ шалгах	Цахим гарын үсэг	

 MINISTRY OF EDUCATION	 GOVERNMENT IMPLEMENTING AGENCY GENERAL AUTHORITY FOR EDUCATION	
<h1>CERTIFICATE OF COMPETENCE</h1>		
Certificate number:	Civil identification number:	Date of issue:
Given name Last name		
Fields of Study/Program name /code/:		
Competence units code: Competence units name:		
Training Provider		
Qualification level:	Credit Hours:	
		
Certificate Verification	Digital Signature	

 <p>БОЛОВСРОЛЫН ЯАМ</p>	<p>Хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний төв</p> <p>Хүтээн : Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p>	 <p>ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРГЭЖүүлэгч АГЕНТЛАГ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР</p>	<p>Хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p> <p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p>
	<p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p>		<p>Хүтээн зөвшөөрч, үйлчилгээний төв</p>

*Боловсролын сайдын 2026 оны 04 дүгээр сарын
28-ны өдрийн А/30 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт*

Загвар 2: Мэргэжлийн үнэмлэхийн загвар /хавтас/



Загвар 2: Мэргэжлийн үнэмлэхийн загвар /нүүр/

<p>МОНГОЛ УЛС</p> <p>МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ Дугаар _____</p>	<p>MONGOLIA</p> <p>VOCATIONAL CERTIFICATE Certificate: _____</p>
<p>_____ нь (РД: _____) аймаг(нийслэл)-ийн _____</p>	<p>This is to certify t _____ (national ID _____) has studied for _____ year/month and successfully completed _____</p>
<p>(мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэр) _____ жил/ сар суралцаж төгссөө.</p>	<p>(name of TVET institution) in _____ province/city.</p>
<p>Индекс: Мэргэжлийн чиглэл/Хөтөлбөр: Мэргэжлийн нэр: Мэргэжлийн түвшин: Боловсролын түвшин: Сургалтын хэлбэр:</p>	<p>Index: Fields of study/Program: Qualification title: Education level: Study mode:</p>
<p>Төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч: Захирал: Олгосон: _____ оны _____ сарын _____ өдөр</p>	<p>Graduation assessment team leader: Director: Issued on: _____</p>
<p>Бүртгэлийн дугаар: _____ </p>	<p>Registration number: _____ </p>

<p style="text-align: center;">ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠤᠨᠡᠮᠯᠡᠬᠡ</p> <p>_____ нь (РД: _____) аймаг(нийслэл)-ийн _____</p> <p>(мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэр) _____ жил/ сар суралцаж төгссөө.</p> <p>Индекс: Мэргэжлийн чиглэл/Хөтөлбөр: Мэргэжлийн нэр: Мэргэжлийн түвшин: Боловсролын түвшин: Сургалтын хэлбэр:</p> <p>Төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч: Захирал: Олгосон: _____ оны _____ сарын _____ өдөр</p> <p>Бүртгэлийн дугаар: _____ </p>	<p style="text-align: center;">MONGOLIA VOCATIONAL CERTIFICATE</p> <p>_____ has studied for _____ year/month and successfully completed _____</p> <p>(name of TVET institution) in _____ province/city.</p> <p>Index: Fields of study/Program: Qualification title: Education level: Study mode:</p> <p>Graduation assessment team leader: Director: Issued on: _____</p> <p>Registration number: _____ </p>
--	---

Мэргэжлийн үнэмлэхийн хавсралтын загвар

№	Чадамжийн нэр А. Ерөнхий суурь чадамжийн нэгжүүд	Мэдлэг		Ур чадвар		№	Чадамжийн нэр		Мэдлэг		Ур чадвар		
		Гүйцэтгэл хувь	Үнэлгээ	Гүйцэтгэл хувь	Үнэлгээ		Б.	Мэргэшүүлэх чадамжийн нэгжүүд	Гүйцэтгэл хувь	Үнэлгээ	Гүйцэтгэл хувь	Үнэлгээ	
1						1							
2						2							
3						3							
4						4							
5						5							
6						6							
7						7							
8						8							
9						9							
10						10							
11						11							
12						12							
13						13							
14						14							
15						15							
Б.	Мэргэжлийн суурь чадамжийн нэгжүүд					Г.	Сонгох чадамжийн нэгжүүд						
1						1							
2						2							
3						3							
4						4							
5						5							
6						6							
7						7							
8						8							
9						9							
10						10							
11						11							
12						12							
13						13							
14													
15													



Тайлбар: Чадамжийн нэрийн үнэлгээний мэдлэг, ур чадварын баганад "чадамжтай" эсвэл "хараахан чадамж эзэмшээгүй" гэж бичнэ.


Мэргэжлийн үнэмлэхийн хавсралтын загвар

Title of competencies		Knowledge		Skills		№ C.	Title of competencies		Knowledge		Skills	
A.	General units of competency	Performance percentage	Final result	Performance percentage	Final result		Specialized units of competency	Performance percentage	Final result	Performance percentage	Final result	
1						1						
2						2						
3						3						
4						4						
5						5						
6						6						
7						7						
8						8						
9						9						
10						10						
11						11						
12						12						
13						13						
14						14						
15						15						
B. Basic professional units of competency						D. Elective units of competency						
1						1						
2						2						
3						3						
4						4						
5						5						
6						6						
7						7						
8						8						
9						9						
10						10						
11						11						
12						12						
13						13						
14	Note: The columns of final result of knowledge and skills shall be filled out either as "Competent" or "Not yet competent"											
15												




**Боловсролын сайдын 2026 оны 04 дүгээр сарын
28-ны өдрийн А/30 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт**

Загвар 3: Дипломын загвар /хавтас/

<p>МОНГОЛ УЛС БОЛОВСРОЛЫН ЯАМ</p>  <p>ДИПЛОМ</p>
<p>Тайлбар:</p> <ol style="list-style-type: none">1. Диплом нь А4 хэмжээтэй улаан өнгийн хамгаалалтын хавтастай байна.2. Хавтасны гадна талд хэвлэгдэх Монгол Улсын төрийн сүлд, бичвэр алтан шармал өнгөтэй байна.3. Засгийн газрын тухай хуулийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг тухайн үеийн нэршлээр бичнэ.

Загвар 3: Дипломын загвар /нүүр/

Бүртгэлийн дугаар:	
МОНГОЛ УЛСЫН ИРГЭН	
овогтой	нь (РД:)

“ _____ ОНД _____ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙГ _____ ”	
МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР (_____) СУРАЛЦАЖ ТӨГССӨН	
ТУЛ ТӨГСӨЛТИЙН КОМИССЫН _____ ОНЫ _____ Р САРЫН _____ -НЫ ӨДРИЙН ШИЙДВЭРИЙГ	
ҮНДЭСЛЭН ЗАХИРЛЫН _____ ОНЫ _____ Р САРЫН _____ -НЫ _____ ДУГААР ТУШААЛААР	
_____ ДИПЛОМ ОЛГОВ.	
Захирал:	Төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч:
_____ / _____ /	_____ / _____ /
нэр/гарын үсэг/тэмдэг	нэр/гарын үсэг/тэмдэг
	

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар А/123

Улаанбаатар
хот

ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.15 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/257 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “ИНД-139 Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт” дүрэмд дор дурдсан агуулгатай (аа) заалтыг 139.5 дугаар зүйлд нэмсүгэй:

“(аа) Энэ зүйл нь дараах төрлийн аэродромд хамаарна:

(1) агаарын тээврийн тогтмол нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг нисэх онгоцонд үйлчлэх дараах аэродромд:

(i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх, нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; эсхүл

(ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах, нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром;

(2) зорчигч тээвэрлэх, агаарын тээврийн тогтмол нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг, 30-аас дээш зорчигчийн суудлын багтаамжтайгаар гэрчилгээжсэн нисэх онгоцонд үйлчлэх аэродром.”

2.Дүрмийн 139.9-д “(d) Хүсэлт гаргагч болон түүний удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх ёстой.”, 139.51 (d)(1)-д “(iii) Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичиг;” гэсэн заалтыг тус тус нэмсүгэй.

3.Дүрмийн 139.55(с)-д “...139.2(а) (2)-т” гэснийг “139.5(аа)(2)-т” гэж, 139.59(а)-д “...139.2(а)(1)-д” гэснийг “139.5 (аа)(1)-т” гэж, 139.77 (а)(16)-д “... 139.121” гэснийг “139.129” гэж, “139.77(а) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна” гэснийг “139.77(б) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна” гэж, 139.77(а) (1А)-д “100.3(ь)” гэснийг “100.3”

гэж, 139.417 (а) (1А)-д “100.3(b)” гэснийг “100.3” гэж, Хавсралт Е-ийн Е.3.14 (а)-д “350 м” гэснийг “300 м” гэж Е.3.14 (ь)-д “350 м” гэснийг “300 м” гэж, Е.3.16-д “350 м” гэснийг “300 м” гэж, Е.3.18-д “350 м” гэснийг “300 м” гэж, Е.3.21-д “350 м” гэснийг “300 м” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор дүрмийн 139.2 дугаар зүйлийг хүчингүй болгосугай.

5.“ИНД-139 “Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт” дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын хэлтэс (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А/129

Улаанбаатар
хот

ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/280 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт” дүрэмд хавсралт ёсоор өөрчлөлт оруулсугай.

2.“ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт” дүрэмд оруулсан өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын хэлтэс (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны
өдрийн А/129 дүгээр тушаалын хавсралт*

**“ИНД-21 БҮТЭЭГДЭХҮҮН, ЭД АНГИЙН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ”
ДҮРЭМД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ**

“ИНД-21 Бүтээгдэхүүн эд, ангийн гэрчилгээжүүлэлт” дүрмийн “Хавсралт С - НТЧ-ын загварын стандарт”-ын (а)-д “Энэ зүйлийн (с)-г харгалзан, стандарт категорийн НТЧ-ын загварын стандарт нь дараах баримт бичгээс бүрдэнэ:

(1) АНУ-ын Холбооны Нисэхийн Захиргаа (цаашид “FAA” гэх)-наас гаргасан Холбооны нисэхийн дараах дүрэм:

(i) Part 23 НТЧ-ын Стандарт: Ердийн, Өргөн хэрэглээний, Аэробатик болон Коммютер категорийн нисэх онгоц, 23.785(а) болон 23.807(b)(5)-аас бусад;

(ii) Part 25 НТЧ-ын Стандарт: Тээврийн категорийн нисэх онгоц;

(iii) Part 27 НТЧ-ын Стандарт: Ердийн категорийн роторт-хөлөг;

(iv) Part 29 НТЧ-ын Стандарт: Тээврийн категорийн роторт-хөлөг;

(v) Part 31 НТЧ-ын Стандарт: Хүнтэй чөлөөт бөмбөлөг;

(vi) Part 33 НТЧ-ын Стандарт: Агаарын хөлгийн хөдөлгүүр;

(vii) Part 35 НТЧ-ын Стандарт: Сэнс; эсхүл

(2) Конвенцын хэлэлцэн тохиролцогч зохион бүтээгч улсын шаардлагыг хангасан гэж Даргын тодорхойлсон НТЧ-ын загварын стандарт” гэснийг

“Энэ зүйлийн (с)-г харгалзан, стандарт категорийн НТЧ-ын загварын стандарт нь дараах баримт бичгээс бүрдэнэ:

(1) ИНД-21-ийн Хавсралт С(а)(1)-т ИНЕГ нь Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгохдоо дараах гадаад улсын маягийн гэрчилгээг хүлээн зөвшөөрч болно:

(i) Европын нисэхийн аюулгүй байдлын агентлаг (EASA), Холбооны нисэхийн удирдах газар (FAA)-аас олгосон маягийн гэрчилгээ;

(ii) EASA, FAA-ээс хүлээн зөвшөөрсөн маягийн гэрчилгээ.

(2) Дээр дурдсанаас бусад Конвенцын хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн байгууллагаас олгосон маягийн гэрчилгээ нь тухайн бүтээгдэхүүний маягийн зөвшөөрлийг эзэмшигчийн Конвенцын Хавсралт 8, 16-д заасан шаардлагуудыг хангасан болохыг нотлон харуулсан байх бөгөөд энэ нь Дарга хүлээн зөвшөөрсөн тохиолдолд” гэж өөрчилсүгэй.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А/130

Улаанбаатар
хот

ДҮРЭМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/255 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар баталсан “ИНД-67 Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ” дүрэмд оруулах нэмэлтийг хавсралт ёсоор баталсугай.

2.“ИНД-67 Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ” дүрмийн нэмэлтийг мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын хэлтэс (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны
өдрийн А/130 дугаар тушаалын хавсралт*

“ИНД-67 ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАНДАРТ БОЛОН ГЭРЧИЛГЭЭ” ДҮРМИЙН НЭМЭЛТ

I Бүлэг – Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч

67.401 Зорилго

(а) Энэ Бүлэг нь зохих ёсоор мэргэшсэн эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмчийг томилоход тавигдах шаардлагыг тогтооно.

(б) Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч томилогдсон тохиолдолд эрүүл мэндийн мэргэжлийн үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн үнэлгээний аудит болон шаардлагатай тохиолдолд эмнэл зүйн эксперт дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

67.403 Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмчид тавигдах шаардлага

(а) Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч нь нарийн мэргэжлийн эмч байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

(1) нарийн мэргэжлийн эмч бол;

(2) дараах шаардлагыг хангасан бол;

(i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн анагаах ухааны сургалтыг амжилттай дүүргэсэн байх;

(ii) Нисэхийн анагаах ухааны чиглэлээр ажиллаж байсан дадлага туршлагатай байх;

(iii) Нисэхийн эрүүл мэндийн ноцтой байдлыг үнэлэх чадвартай байх;

(iv) Даргын шаардаж болох нисэхийн анагаахын болон нисэхийн хууль, дүрмийн сургалтад хамрагдан мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тогтмол шинэчилж, хадгалдаг байх;

(б) Эрүүл мэндийн чиглэлийн хяналт шалгалт, тандалт, магадлан итгэмжлэл болон эрсдэлд суурилсан гэрчилгээжүүлэлтийн зарчмын талаар мэдлэгтэй байх;

(с) Эрүүл мэндийн мэдээллийн нууцлалыг холбогдох хууль тогтоомж, болон батлагдсан заавар, журмын дагуу хамгаалах чадвартай байх.

(д) Хавсралт А-д заасан холбогдох ур чадварыг хангаж байгаагаа Даргад батлан харуулсан байх.

67.405 Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмчийн үйл ажиллагааны шаардлага

(а) Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч мэргэжлийн үнэмлэх,

зэрэглэл эзэмшдэг нисэхийн ажилтнуудын ажил үүргийн бодит нөхцөл байдлын талаар практик мэдлэгтэй байна. Уг мэдлэгийг дараах хэлбэрээр олж авч болно:

(1) нисэх багийн ажлын орчны ажиглалт, эсхүл нислэгийн туршлага;

(2) нислэгийн симуляторын дадлага, эсхүл ажиглалт;

(3) ажлын байрны бодит ажиглалт;

(4) нислэгийн үйл ажиллагаа, эсхүл нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид үйл ажиллагааны орчинтой танилцах дадлага хийх.

(b) Жилд 10-аас доошгүй цаг нисэхийн ажилтнуудын ажил үүргийн бодит нөхцөл байдлын талаарх практик мэдлэгийг хадгалах.

67.407 Чиг үүрэг

(a) Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч нь ИШЭ-ээс ирүүлсэн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, үнэлгээний тайлан болон холбогдох баримт бичгийн бүрдлийг дүрмийн болон Ерөнхий зааварт заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ.

(b) Стандарт бус, НЭМНБ-д хамаарах тохиолдлыг үнэлэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

(1) Дүрмийн шаардлага болон эрүүл мэндийн стандартыг бүрэн хангаагүй тохиолдлуудыг үнэлж, шаардлагатай тохиолдолд нэмэлт шинжилгээ, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн дүгнэлтийг шаардах;

(2) Уян хатан нөхцөлөөр эрүүл мэндийн гэрчилгээ олгох, үйл ажиллагааны хязгаарлалт, итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт шаардлагатай тохиолдолд нисэхийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх;

(3) Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргах бүрэлдэхүүнд зохих чиглэлийн эксперт эмч, ИШЭ, үйл ажиллагааны нэгжүүдийн төлөөллийг татан оролцуулах.

(c) Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч нь ИШЭ-ийн үйл ажиллагаанд стандарт тогтоох, хяналт тавьж, мэргэжлийн зөвлөмжөөр хангаж ажиллана.

(d) Эрүүл мэндийн үнэлгээ хариуцсан эмч нь ИШЭ-ийн үйл ажиллагаанд Ерөнхий зааварт заасны дагуу эрүүл мэндийн гэрчилгээ олгоход шаардлагатай үзлэг, шинжилгээний тайланд аудит шалгалт хийнэ. Үүнд:

(1) ИШЭ-ийн үзлэгийн дүгнэлт, үнэлгээний тайлан дүрмийн нийцлийг хангаж байгаа эсэх;

(2) Монгол Улсад ашиглагдаж байгаа эмнэл зүйн практик удирдамжийг зөв хэрэгжүүлсэн эсэх;

(3) Нэмэлт үзлэг, нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагыг

зөв тодорхойлсон эсэх.

(e) Нисэхийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг хийн, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх сэдвийн хүрээг тодорхойлж салбарын оролцогч талуудыг мэдээллээр хангана.

(f) ИШЭ-ийн үйл ажиллагаанд шаардагдах мэргэжлийн зөвлөгөөн хийх, нисэхийн анагаах ухааны давтан сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, зохион байгуулна.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А/131

Улаанбаатар
хот

ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/282 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “ИНД-121 Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийг нэгдүгээр хавсралтаар, хоёрдугаар хавсралтаар баталсан “ИНД-125 Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд орох нэмэлтийг хоёрдугаар хавсралтаар, гуравдугаар хавсралтаар баталсан “ИНД-135 Нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд орох нэмэлтийг гуравдугаар хавсралтаар, дөрөвдүгээр хавсралтаар баталсан “ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын хэлтэс (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Зам, тээврийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/131 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

“ИНД-121 ТОМ НИСЭХ ОНГОЦНЫ АРИЛЖААНЫ НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА” ДҮРЭМД ОРОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг. “ИНД-121 Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд оруулах нэмэлт:

1.1. ИНД-121-ийн 121.802-т “(ba). Энэ зүйлийн (b)(2) болон (b)(3)-ыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” гэж;

1.2. ИНД-121-ийн 121.403 НТЧ-ын хариуцлага

“121.403(b)(2) заалтын “... байгууллага” гэсний дараа “хувь хүн” гэж, 121.403(b)(2)(i) заалтын “... байгууллага, эсхүл” гэсний дараа “ИНД-66-ын дагуу олгосон хүчин төгөлдөр, тохирох категори болон зэрэглэлтэй Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэх эзэмшигч, эсхүл.” гэж тус тус нэмэх.

Хоёр. “ИНД-121 Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд оруулах өөрчлөлт:

2.1. ИНД-121-ийн 121.89. Нислэгийн бичлэгийн төхөөрөмжид тавих шаардлага

“(с) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн бичлэгийн төхөөрөмжийн байнгын ажиллагаатай байдлыг хангах зорилгоор “Component Maintenance Manual”-н дагуу нислэгийн бичлэгийн төхөөрөмжийн системийн бичлэгийн чанарт үйл ажиллагааны шалгалт болон тохируулгыг хийдэг болохыг бататгах үүрэгтэй.” гэснийг

“(с) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн өгөгдөл бүртгэгч (FDR)-тэй холбоотой дараах баримт бичгийг боловсруулж, байнга шинэчлэн хадгална:

(1) параметрийн хуваарилалт (parameter allocation);

(2) хувиргалтын тэгшитгэлүүд (conversion equations);

(3) хугацаат шалгалт тохируулга (periodic calibration);

(4) ашиглалтын болон техник үйлчилгээний бэлэн байдлын мэдээлэл (serviceability/maintenance information).

Эдгээр баримт бичиг нь хангалттай түвшинд боловсруулагдсан байх бөгөөд ослын болон зөрчлийн мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд нислэгийн өгөгдлийг инженерийн нэгжид зөв тайлж уншихад шаардлагатай бүх мэдээллийг агуулсан байна.” гэж өөрчлөх.

*Зам, тээврийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны
өдрийн А/131 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт*

**“ИНД-125 ДУНД НИСЭХ ОНГОЦНЫ АРИЛЖААНЫ НИСЛЭГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА” ДҮРЭМД ОРОХ НЭМЭЛТ**

Нэг. “ИНД-125 Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд оруулах нэмэлт:

1.1. ИНД-125-ын 125.403 НТЧ-ын хариуцлага

“125.403(b)(2) заалтын “... байгууллага” гэсний дараа “хувь хүн” гэж, 125.403(b)(2)(i) заалтын “... байгууллага, эсхүл” гэсний дараа “ИНД-66-ын дагуу олгосон хүчин төгөлдөр, тохирох категори болон зэрэглэлтэй Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэх эзэмшигч, эсхүл.” гэж,

1.2. ИНД-125-ын 125.802-т “(ba). Энэ зүйлийн (b)(2) болон (b)(3)-ыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” гэж тус тус нэмэх.

*Зам, тээврийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны
өдрийн А/131 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт*

**“ИНД-135 НИСДЭГ ТЭРЭГ БОЛОН ЖИЖИГ НИСЭХ ОНГОЦНЫ
АРИЛЖААНЫ НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА” ДҮРЭМД ОРОХ
НЭМЭЛТ**

**Нэг. “ИНД-135 Нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоцны
арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрэмд оруулах нэмэлт:**

1.1. ИНД-135-ын 135.802-т “(ba). Энэ зүйлийн (b)(2) болон (b)(3)-ыг
2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө” гэж,

1.2. ИНД-135-ын 135.402. Техник үйлчилгээний сонголт
“135.402(c) заалтын “.... байгууллага” гэсний дараа “хувь хүн” гэж,
135.402(c)(1) заалтын “.... байгууллага, эсхүл” гэсний дараа “ИНД-66-
ын дагуу олгосон хүчин төгөлдөр, тохирох категори болон зэрэглэлтэй
Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэх эзэмшигч,
эсхүл.” гэж,

1.3. ИНД-135-ын 135.402. Техник үйлчилгээний сонголт
“135.402(d) заалтын “.... байгууллага” гэсний дараа “хувь хүн” гэж,
135.402(d)(3) заалтын “.... байгууллага, эсхүл” гэсний дараа “ИНД-66-
ын дагуу олгосон хүчин төгөлдөр, тохирох категори болон зэрэглэлтэй
Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэх эзэмшигч,
эсхүл.” гэж тус тус нэмэх.

Зам, тээврийн сайдын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/131 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт

“ИНД-119 АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ” ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг. “ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” дүрэмд оруулах нэмэлт:

1.1.ИНД-119-ийн 119.63(b)-д “(11) хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд хүний хүчин зүйлийн зарчмыг мөрдлөг болгосон байна.” гэж,

1.2.ИНД-119-ийн 119.61 Техник үйлчилгээний журам

“119.61(b)(4) удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын нэрс болон гүйцэтгэх үүрэг, хариуцлага;

119.61(b)(5)-д удирдах ажилтнуудын үүрэг, хариуцлага, үүнд хариуцсан чиг үүргийн хүрээнд тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харилцах асуудал;

119.61(b)(6)-д техник үйлчилгээний хөтөлбөрийг хангаж ажиллах журам;

119.61(b)(7)-д техник үйлчилгээний бүртгэлийг хөтлөх болон хадгалах аргачлалын журам;

119.61(b)(8)-д НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэл, хэрэгжүүлэх журам;

119.61(b)(9)-д баримт бичгийн хяналтын журам” гэж тус тус нэмэх.

Хоёр. “ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” дүрэмд оруулах өөрчлөлт:

2.1. ИНД-119-ийн 119.61. Техник үйлчилгээний журам

“(а) АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах агаарын хөлөг, төхөөрөмжийн Техник үйлчилгээний хяналтын журмыг хэрэгжүүлсэн байх үүрэгтэй:

(1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг;

(2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн төхөөрөмж” гэснийг

“(а) АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг болон тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн төхөөрөмжийн хувьд дараах мэдээллийг багтаасан Техник үйлчилгээний хяналтын журмыг хэрэгжүүлсэн байх үүрэгтэй:

(1) ажилтнуудын нэрс болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага;

(2) техник үйлчилгээний хөтөлбөр лүү холбосон баримт бичгийн ишлэл;

(3) техник үйлчилгээний бүртгэлийг хөтлөх болон хадгалах аргачлал;

(4) НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэл, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалт;

(5) баримт бичгийн хяналт” гэж,

2.2.ИНД-119-ийн “119.63(b)-д “Энэ зүйлийн (а)-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах мэдээллийг багтаасан байна” гэснийг “Энэ зүйлийн (а)-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа хүний хүчин зүйлийн зарчмыг мөрдлөг болгож, энэ дүрмийн Хавсралт С-д заасан зааврын бүтэц, агуулгад тавигдах шаардлагыг хангасан байна” гэж,

2.3.ИНД-119-ийн 119.63(b)(2)-т “агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, даах сэнс, хэрэгсэл, ослын төхөөрөмжийн шаардлагатай үзлэг шалгалт, тест болон дараах эд анги, түүний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм (цаашид “ИНД-91” гэх)-ийн G Бүлэг болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарьт заасан минимум шаардлагатай дүйцэх зааварчилгаа, журам” гэснийг “агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, даах сэнс, хэрэгсэл, ослын төхөөрөмжийн шаардлагатай үзлэг шалгалт, гэрчилгээжүүлэлт шаардсан техник үйлчилгээний ажлуудыг тодорхойлох, тест болон дараах эд анги, түүний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм (цаашид “ИНД-91” гэх)-ийн G Бүлэг болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарьт заасан минимум шаардлагатай дүйцэх зааварчилгаа, журам” гэж,

2.4.ИНД-119-ийн 119.63(b)(4)-т “агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт шилжүүлэх журам” гэснийг “агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт шилжүүлэх журам, шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийн бүтцийн бүрэн бүтэн байдлыг хангах хөтөлбөрийг тусгах” гэж,

2.5.ИНД-119.61(d) болон 119.109(d)-д “Хүсэлт гаргагч нь Техник үйлчилгээний хөтөлбөр боловсруулахдаа хүний хүчин зүйлийн зарчмыг мөрдлөг болгосон байна” гэснийг “Хүсэлт гаргагч нь Техник үйлчилгээний хөтөлбөр боловсруулахдаа хүний хүчин зүйлийн зарчмыг мөрдлөг болгож, энэ дүрмийн Хавсралт С-д заасан зааврын бүтэц, агуулгад тавигдах шаардлагыг хангасан байна.” гэж тус тус өөрчлөх.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар А/133

Улаанбаатар
хот

ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/313 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “ИНД-13 Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх” дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2.”ИНД-13 Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх” дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын хэлтэс (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 01-ний
өдрийн А/133 дугаар тушаалын хавсралт*

“ИНД-13 ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРМИЙГ АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ” ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг. ИНД-13 “Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх”-д оруулах нэмэлт:

1.1.ИНД-13-ийн 13.53 Хяналт шалгалтын дагуу авах арга хэмжээ
“13.53(b) Дарга нь иргэний нисэхийн баримт бичиг эзэмшигчийг хууль тогтоомж, дүрмийн шаардлага, эсхүл олгогдсон гэрчилгээ, зөвшөөрлийн нөхцөлийг зөрчсөн, эсхүл олгосон баримт бичгийн зарим хэсгийн нөхцөл шаардлагыг хангахгүй болсон гэж үзсэн тохиолдолд тухайн баримт бичгийн хамаарах хэсгийн хүчинтэй байдалд хязгаарлалт тогтоож болно. Үүнд:

(1) Байгууллагын хувьд гэрчилгээ, зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны хүрээг багасгах, үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, хувь хүний хувьд үнэмлэхээр олгогдсон эрх, зэрэглэлийг хязгаарлах;

(2) Дарга хязгаарлалт тогтоох болсон үндэслэл болон авах арга хэмжээний талаарх мэдээллийг багтаасан мэдэгдлийг баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээдэд бичгээр хүргүүлнэ;

(3) Хязгаарлалт нь баримт бичиг эзэмшигч шаардлагатай залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, холбогдох шаардлагыг бүрэн хангаж байгааг Дарга хангалттай гэж үзэх хүртэл хүчин төгөлдөр байна.” гэж тус тус нэмэх.

Хоёр. “ИНД-13 Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх” дүрэмд оруулах өөрчлөлт:

2.1. ИНД-13-ийн 13.53 Хяналт шалгалтын дагуу авах арга хэмжээ
“13.53(c) заалтад “..... энэ зүйлийн (b)(5)-д” гэснийг “.... энэ зүйлийн (a)(5)-д” гэж өөрчлөх.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авсан

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 4 дүгээр
сарын 08-ны өдөр

Дугаар 270

Улаанбаатар
хот

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/1264 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Үйлчлэх хугацаа нь дуусч дагаж мөрдөхгүй болсонтой холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 227, 230, 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 457 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

2.Дээрх актуудыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлээс хасуулж хөдөлгөөн хийлгэхийг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ
А.АЗБАЯР
Д.ЦОГОО
Б.ЭНХЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ